



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Монгол Улсын 2015 оны нэгдсэн төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудит

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Гүйцэтгэлийн
аудитын газар

Газрын дарга,
тэргүүлэх аудитор

М.Наранжаргал

Аудитын менежер

С.Оюунгэрэл

Ахлах аудитор

Д.Гандолгор

Аудитор

Ц.Цолмон

Шинжээч

Х.Энх-Амгалан

Г.Батсүх

Б.Ариунжаргал

Н.Эрдэнэбаяр

2016 оны 6 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын
цахим хуудаснаас үзнэ үү:

www.audit.mn

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 263755 дугаарын
утсаар харилцана уу.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар

Чингэлтэй дүүрэг,

Засгийн газрын 4 дүгээр байр,

Бага тойруу-3

Улаанбаатар-15160

Монгол Улс

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
БҮЛЭГ 1 МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ	4
1.1 Нэгдсэн төсвийн орлого	4
1.2 Нэгдсэн төсвийн зарлага	7
1.3 Нэгдсэн төсвийн тэнцэл	7
1.4 Монгол Улсын Засгийн газрын өр	8
БҮЛЭГ 2 МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ ТӨСӨВ	13
2.1 Улсын төсвийн орлого	13
2.2 Улсын төсвийн зарлага	17
2.3 Улсын төсвийн тэнцэл	19
БҮЛЭГ 3 ОРОН НУТГИЙН 2015 ОНЫ ТӨСӨВ	20
3.1 Орон нутгийн төсвийн орлого	20
3.2 Орон нутгийн зарлага	22
3.3 Орон нутгийн төсвийн тэнцэл	24
БҮЛЭГ 4 ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2015 ОНЫ ТӨСӨВ	24
4.1 Хүний хөгжил сангийн төсвийн орлого	24
4.2 Хүний хөгжил сангийн төсвийн зарлага	24
4.3 Хүний хөгжил сангийн төсвийн тэнцэл	25
БҮЛЭГ 5 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2015 ОНЫ ТӨСӨВ	25
5.1 Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого	25
5.2 Нийгмийн даатгалын сангийн төсвийн зарлага	26
5.3 Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл	26
БҮЛЭГ 6 НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	27
ДҮГНЭЛТ	28
ХАВСРАЛТ	29-31
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ	32

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АҮЯ	Аж үйлдвэрийн яам
АТБӨЯХАТ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОНХАЖС	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БХС	Батлан хамгаалахын сайд
ГХС	Гадаад хэргийн сайд
ГТГ	Газрын тосны газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТС	Зам тээврийн сайд
ЖДҮДС	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДС	Нийгмийн даатгалын сан
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОАТ	Онцгой албан татвар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
тбм	тэрбум төгрөг
тн	Тонн
УИХ	Улсын Их Хурал
УЕП	Улсын Ерөнхий прокурор
УУЯ	Уул уурхайн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ХХААС	Хүнс, хөдөө аж ахуйн сайд
ХАХНХС	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд
ХЗС	Хууль зүйн сайд
ХХС	Хүний хөгжил сан
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭМСС	Эрүүл мэнд, спортын сайд

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Үндэсний аудитын газар Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2¹ дахь заалтын дагуу Монгол Улсын 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд 2016 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдрийн хооронд аудит хийв.

Аудитын зорилт

Монгол Улсын 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Хамарсан хүрээ

Сангийн яам Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7²-д заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны гүйцэтгэлийн тайлан, танилцуулгыг дараах бүрэлдэхүүн хэсэг, дараалалтай тайлагнажээ. Үүнд:

- Монгол Улсын 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл
- Монгол Улсын 2015 оны төсвийн гүйцэтгэл
- Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн гүйцэтгэл
- Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн гүйцэтгэл
- Орон нутгийн төсвийн 2015 оны гүйцэтгэл
- Монгол Улсын Засгийн газрын өрийн талаарх танилцуулга

Танилцуулгын хавсралт мэдээлэлд:

- Монгол Улсын 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, тэнцэл,
- Монгол Улсын 2015 оны төсвийн гүйцэтгэл, үр дүнгийн үзүүлэлт
- Засгийн газрын өрийн үзүүлэлтүүд
- Орон нутаг, ХХС, НДС-гийн төсвийн гүйцэтгэл
- Татварын зарлагын хэмжээ
- Улсын төсөв, Хөгжлийн банкны хөрөнгө оруулалт
- Гадаад зээлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт
- Засгийн газрын нөөц сангийн гүйцэтгэл
- 2015 оны нэмэлт төсвийн зарлагын гүйцэтгэлийн тайлан
- ТЭЗ нарын 2015 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг тус тус харуулсан байна.

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитын олон улсын стандарт, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитыг гүйцэтгэсэн бөгөөд Сангийн яам болон бусад холбогдох яам, байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа авах, дансны хуулгатай тулган баталгаажуулах, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.

Нэгдсэн төсвийн 2015 оны гүйцэтгэлийн аудитын тайланд Орон нутгийн төсвийн гүйцэтгэлд нэгдсэн удирдамжаар хийсэн аудитын дүнг нэгтгэлээ. Түүнчлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тусад нь аудит хийсэн тул уг тайланд оруулаагүй болно.

Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

¹ “төрийн аудитын төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэг сарын дотор аудит хийж, Засгийн газар, Улсын Их Хуралд хүргүүлэх”

² нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ

1.1 Нэгдсэн төсвийн орлого

1.1.1. Нэгдсэн төсвийн 2015 оны тэнцвэржүүлсэн орлогыг төлөвлөхдөө төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцүүлж, 2014 оны гүйцэтгэлээс³ 14.1 хувиар нэмэгдүүлэн 7,159.9 тэрбум төгрөгт хүрэхээр тооцоолсон байна.

1.1.2. Төсвийн орлогын төлөвлөгөөнд зэс, коксжих болон боловсруулсан чулуун нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг хүснэгтэд үзүүлснээр тооцож, уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтаас орох татварын орлогыг 984.2 тэрбум төгрөг байхаар тусгажээ.	/хүснэгт №1/	/үнийн дундаж, тн ам.доллороор/
	Алт	<u>1,175</u>
	Зэс	6,354.7
	Боловсруулсан нүүрс	82.5
	Коксжих нүүрс (ккал 5500-с дээш)	38.5
	Чулуун нүүрс (4000-5500ккал)	56.1

1.1.3. Тайлант онд Оюутолгой ХХК 186.1 мянган тн зэс, 19.5 тн алт, 42.8 тн мөнгө агуулсан 775.3 мянган тн зэсийн баяжмал үйлдвэрлэж, улсын төсөвт 286.6 тэрбум төгрөг, Эрдэнэт үйлдвэр 3.5 мянган тн молибден, 114.4 мянган тн зэс, 36.5 тн мөнгө агуулсан 520.0 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэж, улсын төсөвт 338.3 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлэхээр тооцжээ.

1.1.4. УИХ 2015 онд улсын төсөвт 2 удаа тодотгол хийж, анх баталснаас орлогыг 1,069.3 тэрбум, зарлагыг 345.8 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж, нэгдсэн төсвийн нийт орлогыг 6,125.1 тэрбум, нийт зарлагыг 7,530.3 тэрбум төгрөгөөр тодотгон баталсан байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурч, эдийн засгийн өсөлт саарсан нь нэгдсэн төсвийн орлого 141.7 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрөхөд нөлөөлжээ

1.1.5. 2015 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн гүйцэтгэлээр 5,983.4 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 141.7 тэрбум, өмнөх оны гүйцэтгэлээс 333.1 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна. Хүснэгтээр харуулбал:

/хүснэгт №2/	/тэрбум төгрөг/				
	Төсвийн орлогын ангилал, зүйл	2014 оны гүйцэтгэл	Төл	2015 оны Гүйц	Зөрүү Хувь
	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,316.5	6,125.1	5,983.4	-141.7 97.7
	ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	39.9	2.3	2.3	0.0 100.0
	ХХС – АМНАТ	14.3	2.3	2.3	0.0 100.0
	ХХС-Өсөн нэмэгдэх нөөцийн төлбөр	25.6	0.0	0.0	0.0 0.0
	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,276.6	6,122.8	5,981.1	-141.7 97.7
	А. УРСГАЛ ОРЛОГО	6,274.3	5,975.2	5,872.5	-102.7 98.3
	I. ТАТВАРЫН ОРЛОГО	5,157.0	5,110.6	5,119.0	8.4 100.2
	2.2.1. Орлогын албан татвар	1,101.0	999.7	1,170.8	171.1 117.1
	2.2.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	917.6	1,049.0	1,018.2	-30.8 97.1
	2.2.3. Хөрөнгийн албан татвар	50.1	88.5	86.6	-1.9 97.9
	2.2.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,371.7	1,198.6	1,049.6	-149.0 87.6
	2.2.5. Онцгой албан татвар	454.4	644.3	592.3	-52.0 91.9
	2.2.6. Тусгай зориулалтын орлого	39.9	11.1	11.8	-0.7 106.3
	2.2.7. Гаалийн албан татвар	355.3	329.2	320.6	-8.6 97.4
	2.2.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	867.0	790.2	869.1	78.9 109.9
	II. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,117.4	864.6	753.5	-150.0 85.2
	Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	2.3	84.3	55.1	-29.2 65.4
	В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	0.0	63.2	53.5	-9.7 84.7

Эх сурвалж: Сангийн яамны мэдээллээс авав.

³ 2014 онд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 6,276.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байсан.

1.1.6. Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 85.6 хувь татварын, 14.4 хувь татварын бус болон хөрөнгө, тусламжийн орлогоос тус тус бүрдэж байгаа бөгөөд татварын орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээг харуулбал:

/хүснэгт №3/


ҮЗҮҮЛЭЛТ	2011	2012	2013	2014	2015
ДНБ, оны үнээр /тбм.төг/	10,829.6	14,012.0	17,550.2	21,937.2	23,166.8
Татварын орлого	3,668.3	4,203.3	5,072.8	5,157.0	5,119.0
Татварын ачаалал, %	33.8	29.9	28.9	23.5	22.1

1.1.7. Хүснэгтээс харахад 2015 онд ДНБ-ий хэмжээ 2011 оноос 12.3, өмнөх оноос 1.2 их наяд төгрөгөөр өсч, харин ДНБ-д эзлэх татварын ачаалал 22.1 хувьтай байгаа нь 2011 оныхоос 11.7, 2014 оныхоос 1.4 пунктээр тус тус буурчээ.

1.1.8. Манай улсын төсвийн орлогын 18.0 хувийг эзэлж буй зэсийн баяжмал, нүүрс, цайрын баяжмал, төмрийн хүдэр, жонш зэрэг эрдэс бүтээгдэхүүний үнийн бууралтаас шалтгаалан уул уурхайн салбарын төсвийн орлогод эзлэх хувь сүүлийн 5 жилд 28-аас 18 хувь хүртэл 10 пунктээр буурсан байна.

/график №1/

/график №2/



Эх сурвалж: Сангийн яамны тооцоололд суурилав.

1.1.9. Уул уурхайн салбараас 2015 онд нийт [984.2](#) тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч зэсийн баяжмал, нүүрс, төмрийн хүдэр зэрэг ашигт малтмалын олборлолт, экспорт төлөвлөсөн хэмжээнээс давсан, татварын ногдлыг тухайн онд нь багтаан төвлөрүүлэх арга хэмжээ авсан зэргээс шалтгаалан төсөвт 1,088.6 тэрбум төгрөг төвлөрч дээрх орлогын 78.2 хувь буюу 851.2 тэрбум төгрөгийг зэс, 11.2 хувь буюу 122.5 тэрбум төгрөгийг нүүрс, 10.6 хувь буюу 114.9 тэрбум төгрөгийг алт, цайр, төмөр зэрэг ашигт малтмалын бусад орлогоос бүрдүүлсэн байна.

Төсвийн хүрээний мэдэгдлийн орлогоос бусад шалгуур үзүүлэлт хангагдсан байна

1.1.10. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний [мэдэгдлийн](#) тухай хуулийн⁴ 1 дүгээр зүйлд заасан шалгуураас ДНБ⁵-нд эзлэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос бусад үзүүлэлт хангагдсан байна.

1.1.11. 2015 оны төсвийн хүрээний мэдэгдлийн шалгуур үзүүлэлт, гүйцэтгэлийг харуулбал:

/хүснэгт №4/

№	Шалгуур үзүүлэлт	2015	
		хүрэх түвшин	хүрсэн түвшин
1	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого хэмжээ /тбм.төг/	6,074.1	5,981.1
	► ДНБ-д эзлэх хувь	25.8	25.8
2	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тбм.төг/	7,253.3	7,137.9

⁴ Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуулийн 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдөр тодотгон баталснаар авав.

⁵ ДНБ /оны үнээр/ 23,166.8

	▶ ДНБ-д эзлэх хувь	30.8	30.8
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тбм.төг/	(1,179.2)	(1,156.9)
	▶ ДНБ-д эзлэх хувь	(5.0)	(5.0)
4	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тбм.төг/	1,530.7	1,396.7
	▶ ДНБ-д эзлэх хувь	6.5	6.0
5	Засгийн газрын өрийн нийт хэмжээ өнөөгийн үнэ цэнээр /тбм.төг/	13,740.0	12,124.2
	▶ ДНБ-д эзлэх хувь	58.3	52.3
6	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжих зардлын нийт хэмжээ /тбм.төг/	284.9	261.9
	▶ ДНБ-д эзлэх хувь	1.2	1.1

1.1.12. 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэлд ДНБ-ий бодит өсөлт 3.1 хувь байхаар тооцсон ч гүйцэтгэлээр 2.3 хувь буюу 0.8 пунктээр бага гарчээ.

1.1.13. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд Улсын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг⁶ /2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр баталсан/ 2015 оны төсвийн жилд 58.3 хувиас хэтрүүлэхгүй байхаар хуульчилсан байна.

1.1.14. Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хууль /2015 оны 10 дугаар сарын 30-нд баталсан/-д заасан Засгийн газрын өрийн тусгай шаардлага⁷ нь Улсын өрөөр тодорхойлогдож байхад тогтоосон шалгуур үзүүлэлт учир тусгай шаардлагыг хангаж байгаа нь эргэлзээтэй байна.

Зэс, нүүрсний зах зээлийн үнэ тэнцвэржүүлсэн үнээс доогуур байснаас тогтворжуулалтын санд орлого төвлөрөөгүй байна

1.1.15. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3⁸-т заасны дагуу тооцсон гол нэр төрлийн эрдэс баялаг зэс, нүүрсний 2015 оны тэнцвэржүүлсэн үнийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал,

/хүснэгт №5/

Бүтээгдэхүүний төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Зэс	6,354.7	5,510.5	(844.2)
Боловсруулаагүй нүүрс /5500 ккал хүртэл/	30.0	30.8	0.8
Боловсруулаагүй нүүрс /5500 ккал-с дээш/	37.1	41.1	4.0
Баяжуулсан коксжих нүүрс	56.1	59.9	3.8

*Тайлбар: 1тн-ыг ам.доллараар тооцсон дүнгээр

1.1.16. Тогтворжуулалтын санд зэсийн орлогоос [29.8](#) тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн⁹ боловч 2015 оны Төсвийн тухай хуулиар 2.3 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулахаар баталсан байна.

1.1.17. Тайлант онд Эрдэнэт үйлдвэр, Оюутолгой ХХК-иас нийт 300.5 мянган тн зэс агуулсан 1,295.3 мянган тн зэсийн баяжмал борлуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 332.9 мянган тн зэс агуулсан 1,472.0 мянган тн зэсийн баяжмал борлуулсан боловч зэсийн зах зээлийн үнэ 2015 оны турш тэнцвэржүүлсэн үнээс доогуур байсан тул Төсвийн тогтворжуулалтын санд орлого төвлөрөөгүй байна.

⁶ 19.3.Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн улсын нийт өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2015 оны төсвийн жилд одоо байгаа түвшинд нь буюу 58.3 хувиас, 2016 оны төсвийн жилд 55 хувиас, 2017 оны төсвийн жилд 50 хувиас, 2018 оны төсвийн жилээс эхлэн 40 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна.


⁷ Өрийн удирдлагын тухай хуулийн 3.4.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргах, түүнийг бүртгэхээс бусад тохиолдолд тухайн хуулийн этгээдийн өр төлбөрийн харилцаанд энэ хууль хамаарахгүй.

⁸ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд болон жилийн төсвийн төсөлд тусгах гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг аргачлалаар тодорхойлж байх


⁹ нүүрсний тэнцвэржүүлсэн үнэ 2015 оны төсвийн жилд зах зээлийн үнийн таамаглалаас давсан тул тогтворжуулалтын санд нүүрснээс орлого төвлөрөхгүй байхаар тооцсон.

1.1.18. Зэсийн тэнцвэржүүлсэн болон зах зээлийн үнийн зөрүүгээс бий болсон өмнөх оны 2.3 тэрбум төгрөгийг Төсвийн тогтворжуулалтын санд оруулсан ба тус сангийн хуримтлал 2015 оны эцэст 314.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

/график №3/



/график №4/



Эх сурвалж: Сангийн яамны тооцоололд суурилав.

1.2 Нэгдсэн төсвийн зарлага

1.2.1. Нэгдсэн төсвийн нийт зарлага 2015 онд 7,530.3 тэрбум төгрөгөөр батлагдаж 7,137.9 тэрбум төгрөгийн буюу 94.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Эдийн засгийн ангиллаар харуулбал:

/хүснэгт №6/

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Нэгдсэн		Улсын		Орон нутгийн		ХХС		НДС	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	7,530.3	7,137.9	5,218.5	4,996.9	2,317.8	2,079.2	328.8	308.3	1,546.6	1,541.5
Урсгал зарлага	5,959.2	5,718.4	4,240.1	4,025.4	1,741.9	1,647.3	325.5	305.0	1,533.2	1,528.6
Хөрөнгийн зардал	1,621.4	1,396.7	1,039.7	950.7	564.9	429.8	3.3	3.3	13.4	12.9
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-50.3	22.9	-61.3	20.8	10.9	2.1	0	0	0	0

1.2.2. Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлийн 56.0 хувийг улсын, 23.3 хувийг орон нутгийн, 17.3 хувийг НДС-гийн, 3.4 хувийг ХХС-гийн төсөв, нийт зарлагын 80.1 хувийг урсгал зардал, 19.6 хувийг хөрөнгийн зардал, 0.3 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл тус тус эзэлж байна.

1.3 Нэгдсэн төсвийн тэнцэл

1.3.1. Монгол Улсын 2015 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,407.6 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,156.9 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу 250.6 тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнийг төсвийн бүтцээр харуулбал:


/хүснэгт №7/

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2014 оны гүйцэтгэл	2015 оны	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нэгдсэн төсөв	(867.9)	(1,407.6)	(1,156.9)
Улсын төсөв	(1,024.8)	(1,188.8)	(1,165.2)
Орон нутгийн төсөв	(37.5)	(244.6)	(45.4)
Хүний хөгжил сангийн төсөв	114.5	28.1	114.7
Нийгмийн даатгалын сангийн төсөв	79.8	(2.3)	(61.0)

1.3.2. Хүснэгтээс үзвэл, Тайлант онд төлөвлөсөн хэмжээнээс Нийгмийн даатгалын сангийн төсвийн алдагдал 58.6 тэрбум төгрөгөөр өссөн бол улс, орон нутаг, Хүний хөгжил сангийн төсвийн алдагдал 23.6-199.2 тэрбум төгрөгөөр буурсан нь нэгдсэн төсвийн нийт алдагдал 250.6 тэрбум төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

/график №5/



1.3.3. Нэгдсэн төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор тайлант онд 2,751.7 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас арилжаалж, 505.1 тэрбум төгрөгийн гадаад зээл авч, 433.6 тэрбум төгрөгийн улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн байна.

1.3.4. Дээрх эх үүсвэрүүдээс Засгийн газрын үнэт цаасны эргэн төлөлтөд 2,070.2 тэрбум, Засгийн газрын гадаад зээлийн эргэн төлөлтөд 126.4 тэрбум төгрөгийг тус тус зарцуулж, татварын урьдчилгаа төлбөрөөс 293.0 тэрбум төгрөгийг суутган тооцож, үлдэх 1,200.8 тэрбум төгрөгөөр 2015 оны нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлснээр харилцах болон хадгаламжийн дансдын үлдэгдэл 43.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

1.4 Монгол Улсын Засгийн газрын өр

Засгийн газрын өрийн 73.5 хувийг гадаад, 26.5 хувийг дотоод өр эзэлж байна

1.4.1. Засгийн газрын гадаад өрийн бүтэц нь гадаад зээл болон үнэт цаас, өрийн баталгаанаас бүрдэж байна.

1.4.2. Гадаад зээл Монгол Улсын Засгийн газар гадаад орон, олон улсын санхүүгийн байгууллагаас 2015 онд 254.5 сая ам.доллар буюу 505.1 тэрбум төгрөгийн гадаад зээлийг авч ашигласан нь өмнөх оноос 136.1 тэрбум төгрөгөөр илүү байна.

1.4.3. Гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт тайлант онд 168.6 тэрбум, үүнээс үндсэн төлбөрт 126.4 тэрбум, хүүгийн төлбөрт 42.2 тэрбум төгрөгийг төлж, гадаад зээлийн үлдэгдэл¹⁰ 2015 оны жилийн эцсийн байдлаар 2,232.9 сая ам.доллар буюу 4,456.8 тэрбум төгрөг байна.

1.4.4. 2015 онд авч ашигласан нийт зээлийн 43.8 хувь Сангийн сайдад, 33.8 хувь Зам тээврийн сайдад ногдож байгаа ба ТЕЗ-дын авч ашигласан зээлийн хэмжээг харуулбал,

/хүснэгт №8/

/тэрбум төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	Ашиглалт	Нийт зээлд эзлэх хувь
Шадар Сайд	2.3	0.5
Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	2.0	0.4
Сангийн сайд	221.3	43.8
Батлан хамгаалахын сайд	15.2	3.0
Эрүүл мэнд, спортын сайд	41.8	8.3
Барилга, хот байгуулалтын сайд	20.4	4.0
Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	12.5	2.5

¹⁰ Гадаад зээлийн оны эхний үлдэгдэл 3,979.1 тэрбум төгрөг

Зам тээврийн сайд	170.5	33.8
Хүнс, хөдөө аж ахуйн сайд	4.7	0.9
Хөдөлмөрийн сайд	1.2	0.2
Эрчим хүчний сайд	7.6	1.5
Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	1.3	0.3
Нийслэлийн Засаг дарга	4.3	0.8
ТЕЗ-дын авч ашигласан гадаад зээлийн дүн	505.1	100.0

1.4.5. Гадаад үнэт цаас 2015 онд олон улсын зах зээлд 161.2 сая ам.доллар буюу 314.9 тэрбум төгрөгийн /5.96 хувийн хүүтэй/ Дим сам бондыг¹¹ арилжаалж, Чингис¹² болон Дим сан бондын хүүгийн төлбөрт 76.8 сая ам.доллар буюу 149.7 тэрбум төгрөгийн төлбөр хийгдэж, 2015 оны 12 дугаар сарын 31-нээрх нэрлэсэн үлдэгдэл 1,661.2 сая ам.доллар буюу 3,315.8 тэрбум төгрөг байна.

1.4.6. Өрийн баталгаа Засгийн газрын өрийн баталгаа тайлант оны эцэст 2,743.5 тэрбум төгрөг байгаа ба үүнээс Хөгжлийн банкны үнэт цаас 580.0 сая ам.доллар буюу 1,157.7 тэрбум, Хөгжлийн банкны Самурай бонд 30.0 тэрбум иен буюу 497.4 тэрбум, БНХАУ-ын Хөгжлийн банкны 150.0 сая ам.доллар буюу 299.3 тэрбум, Кредит Свисс банкны 300.0 сая ам.доллар буюу 598.8 тэрбум төгрөгийн зээл, “МИАТ” ТӨХК-д гаргасан 95.4 сая ам.доллар буюу 190.3 тэрбум төгрөгийн өрийн баталгаа байна. /ХХБ-ны өрийн баталгааны сан/

1.4.7. Засгийн газрын гадаад өрийн тайлант оны хөдөлгөөнийг харуулбал:

/хүснэгт №9/

Гадаад зээлийн ангилал	/тэрбум төгрөг/					
	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Эргэн төлөлт	Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	Хувь
Хөтөлбөрийн зээл	54.7	199.7	5.3	3.4	252.5	2.4
Төслийн зээл	3,924.4	305.4	121.1	95.6	4,204.3	40.0
Нийт гадаад зээл	3,979.1	505.1	126.4	99.0	4,456.8	-
Чингис бонд	2,828.4	-	-	165.6	2,994.0	28.5
Дим сам бонд	-	314.9	-	6.9	321.8	3.1
Нийт гадаад үнэт цаас	2,828.4	314.9	-	172.5	3,315.8	-
Хөгжлийн банк	2,342.7	73.7		136.7	2,553.1	24.2
МИАТ ТӨХК	201.7		22.8	11.5	190.4	1.8
Өрийн баталгааны дүн	2,544.4	73.7	22.8	148.2	2,743.5	-
Нийт дүн	9,351.9	893.7	149.2	419.7	10,516.1	100.0%

1.4.8. Засгийн газрын гадаад валютаар илэрхийлэгдэж байгаа өрийн багцад ам.доллар 60.9 хувийг, зээлжих тусгай эрх 19.6 хувийг, иен 14.1 хувийг, евро 3.2 хувийг, бусад валют 2.2 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд тайлант оны эцсийн үлдэгдлийн 1 ам.долларын ханшийг 1995.98 төгрөгөөр тооцон илэрхийлсэн байна.

1.4.9. Монгол Улсын Засгийн газрын гадаад орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан зээлийн 59.4 хувийг эрчим хүчний салбарт, 13.6 хувийг зам, тээврийн салбарт, 11.6 хувийг санхүү, эдийн засгийн салбарт, 6.6 хувийг жижиг, дунд үйлдвэрийн салбарт, 4.4 хувийг хөдөө аж ахуйн салбарт, 2.4 хувийг орон сууц, нийтийн аж, ахуйн салбарт ашигласан байна.

¹¹ ЗГ-ын 2015 оны 249 дүгээр тогтоолоор олон улсын зах зээлд 3.5 жилийн хугацаатай, 350 сая хүртэл ам.доллартай тэнцэх хэмжээний юаниар илэрхийлсэн ЗГ-ын үнэт цаас гаргахаар болсны дагуу 3 жилийн хугацаатай 1.0 тэрбум юаньтай тэнцэх үнэт цаас.

¹² 2012 оны 12 дугаар сард 10 жилийн хугацаатай 1.0 тэрбум ам.долларын бондыг 5.125 хувийн хүүтэйгээр, 5 жилийн хугацаатай 500.0 сая ам.долларын бондыг 4.125 хувийн хүүтэйгээр, нийт 1.5 тэрбум ам.долларын Чингис бондыг олон улсын зах зээлд арилжаалсан.

Засгийн газрын дотоод өрийн 87.7 хувийг ЗГҮЦ-ны өглөг эзэлж байна

1.4.10. Дотоод үнэт цаас Засгийн газраас улсын төсвийн мөнгөн хөрөнгийн дутагдал, төсвийн алдагдал болон өрийг дахин санхүүжүүлэх зорилгоор 2015 онд нийт 2,545.5 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий дотоод үнэт цаасыг гаргаж арилжаалсан ба тайлант онд 2,070.3 тэрбум төгрөгийн үнэт цаасыг буцаан төлж, тайлант оны эцэст 3,333.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Эргэн төлөлтийг үнэт цаасны төрлөөр харуулбал:

- Төрийн албан хаагч болон иргэдийг орон сууцны урт хугацаат зээлийн эх үүсвэрээр хангах “4000 айлын орон сууц хөтөлбөр”-ийн хүрээнд гаргасан үнэт цаасны үндсэн төлбөрт 30.0 тэрбум,
- Банкны бүтцийн өөрчлөлтийн хүрээнд гаргасан үнэт цаасны үндсэн төлбөрт 11.0 тэрбум,
- Жижиг, дунд үйлдвэр, ноос, ноолуурын салбарыг дэмжих зорилгоор гаргасан үнэт цаасны үндсэн төлбөрт 4.5 тэрбум,
- Улсын төсвийн болон Хүний хөгжил сангийн төсвийн мөнгөн хөрөнгийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаасны үндсэн төлбөрт 2,024.8 тэрбум төгрөгийг төлжээ.

1.4.11. Төсвөөс эргэн төлөх концесс Өрийн удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.7-д¹³ заасны дагуу 2015 оны жилийн эцсийн байдлаар төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй нийт 7 төслийн хүрээнд гарсан ашиглалт, гүйцэтгэлийн 261.0 тэрбум төгрөгийг өрөөр бүртгэсэн байна.

1.4.12. Вексель УИХ-ын 2015 оны 7 дугаар тогтоол болон Засгийн газрын 2015 оны 105, 282 дугаар тогтоолын дагуу 2008-2014 онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусган хэрэгжүүлсэн хэдий ч бүрэн санхүүжигдээгүй төсөл, арга хэмжээг векселиэр баталгаажуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд 2015 оны жилийн эцсийн байдлаар векселийн үлдэгдэл 164.3 тэрбум төгрөг¹⁴ байна.

1.4.13. Татварын урьдчилгаа төлбөр Оюутолгой ХХК-иас татварын урьдчилгаанд авсан 250.0 сая ам.долларын төлбөрөөс тайлант оны эцэст 20.8 сая ам.доллар буюу 41.4 тэрбум төгрөгийн¹⁵ үлдэгдэлтэй байна.

1.4.14. УИХ-аас 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдөр баталсан Өрийн удирдлагын тухай хуулиар “Улсын өр”-ийн тодорхойлолтыг “Засгийн газрын өр”¹⁶ гэж өөрчилсөн ба өрийн /нэрлэсэн үнээр/ нийт үлдэгдлийг сүүлийн 3 жилийн байдлаар харуулбал:

/хүснэгт №10/ Үзүүлэлт	/тэрбум төгрөг/ 2013 он 2014 он 2015 он		
	Улсын нийт өр	ЗГ-ын нийт өр	
Гадаад зээлийн үлдэгдэл	3,613.2	3,979.1	4,456.8
Гадаад үнэт цаасны үлдэгдэл	2,481.2	2,828.4	3,315.8
Өрийн баталгааны үлдэгдэл	1,160.2	2,544.4	2,743.5
Гадаад өр	7,254.6	9,351.9	10,516.1
Дотоод үнэт цаасны үлдэгдэл	1,849.6	2,964.1	3,333.2
ТӨ ба ТӨ давамгайлсан хуулийн этгээдийн өр	1,629.3	1,438.3	-
ОНӨ ба ОНӨ давамгайлсан хуулийн этгээдийн өр	174.9	174.9	-
Татварын урьдчилгаа төлбөр /Оюутолгой/	372.5	138.7	41.4

¹³ “Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, концессын гэрээний дагуу улирал бүр гарсан ашиглалтыг үндэслэж Засгийн газрын өрд бүртгэнэ”

¹⁴ Махны вексель 4.5 тэрбум, хөрөнгө оруулалтын вексель 159.8 тэрбум төгрөг байна.

¹⁵ 2015 онд Эрдэнэс Тавантолгойн урьдчилгаа 416.1 тэрбум төгрөгийн төлбөрийг барагдуулж дуусссан.

¹⁶ орон нутгийн өмчит болон орон нутгийн өмч давамгайлсан, төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжүүдийн өрийг оруулахгүй болсон

Төсвөөс эргэн төлөх концессийн үлдэгдэл			261.0
Векселийн өр			164.3
Дотоод өр	4,026.3	4,716.0	3,799.9
Өрийн нийт дүн	11,280.9	14,067.9	14,316.0

1.4.15. Засгийн газрын өрийн хэмжээ өмнөх оноос 248.1 тэрбум төгрөгөөр өссөн ба гадаад зээлийн үлдэгдэл 31.1, дотоод үнэт цаасны үлдэгдэл 23.3, гадаад үнэт цаасны үлдэгдэл 23.2, Засгийн газрын өрийн баталгаа 19.2, бусад өр 3.2 хувийг тус тус эзэлж байна.

1.4.16. Худалдаа хөгжлийн банкнаас гадаад зах зээлд борлуулсан 500.0 сая ам.долларын урт хугацаат үнэт цаасанд Засгийн газрын 2015 оны 163 дугаар тогтоолын дагуу гаргасан Засгийн газрын өрийн баталгааны санг 10.0 сая ам.доллар буюу 20.0 тэрбум төгрөгөөр тооцон байгуулж Төрийн сангийн санхүүгийн тайланд тусгасан байна.

Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрийг бүрэн төлсөн байна

1.4.17. 2015 онд Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрт нийт 731.3 тэрбум төгрөгийг төлөхөөр төлөвлөж, 731.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарснаас гадаад зээл, үнэт цаасны хүүгийн төлбөрт 192.2 тэрбум, дотоод зээл, үнэт цаасны хүүгийн төлбөрт 538.9 тэрбум төгрөгийг тус тус төлжээ.

1.4.18. Засгийн газрын шугамаар гадаад орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн төлбөрт тайлант онд 42.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

1.4.19. 2015 онд Засгийн газрын үнэт цаасны хүүгийн зардал, хөнгөлөлтийн төлбөрт 378.4 тэрбум төгрөгийг төлжээ. Үүнд:

- “4000 айлын орон сууц хөтөлбөр”-ийн хүрээнд гаргасан үнэт цаасны хүүнд 2.0 тэрбум,
- Банкны бүтцийн өөрчлөлт, жижиг, дунд үйлдвэр, ноос, ноолуурын салбарыг дэмжих зорилгоор гаргасан үнэт цаасны хүүд 1.7 тэрбум,
- Монголбанкнаас авсан дотоод зээлийн хүүд 2.2 тэрбум,
- Улсын болон Хүний хөгжил сангийн төсвийн мөнгөн хөрөнгийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаасны хүүд 263.0 тэрбум, хөнгөлөлтийн төлбөрт 109.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Буцаан төвлөрүүлэхээр төлөвлөсөн зээлийн 46.0 хувь нь төлөгдөөгүй байна

1.4.20. 2015 оны Төсвийн тухай хуулиар 9 ТЕЗ-ийн төсвийн багцад дотоод эх үүсвэрээс 48.3 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээс 45.3 тэрбум төгрөг, нийт 93.6 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх зээлийг олгож, харин өмнөх онуудад олгосон зээлээс 157.9 тэрбум төгрөгийг буцаан төвлөрүүлэхээр баталсан боловч гүйцэтгэлээр 72.7 тэрбум төгрөг төвлөрсөн байна.

Хүснэгтээр харуулбал:

Төсвийн ерөнхийлөн захирагч		Төсөл хөтөлбөрийн нэр		2015 оны		Зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл			
Олгосон зээл, үүнээс		96.4	93.6	(2.8)		
Ерөнхий сайд	Мэдээлэл холбооны нэгдсэн холбоо шинэчлэл төсөл	4.9	-	(4.9)		
Барилга хот байгуулалтын сайд	Олгох зээл /4 төсөл, арга хэмжээ/	17.6	27.5	9.9		
Зам тээврийн сайд	Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх төсөл	1.9	-	(1.9)		
Эрчим хүчний сайд	Олгох зээл /6 төсөл, арга хэмжээ/	4.9	6.9	1.1		
Хөдөлмөрийн сайд	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" сан	13.0	11.0	(2.0)		
Аж үйлдвэрийн сайд	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан	11.0	12.0	1.0		
Хүнс, хөдөө аж ахуйн сайд	Зах зээл, бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл	1.7	1.8	0.1		

	Мал хамгаалах сан	1.9	1.3	(0.6)
Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд	Сургалтын төрийн сан	23.8	18.2	(5.6)
Сангийн сайд	Олгох зээл /5 төсөл, арга хэмжээ/	15.7	14.9	(0.8)
Буцаан төлөгдсөн зээл, үүнээс		(157.9)	(72.7)	(85.2)
Аж үйлдвэрийн сайд	ЖДҮДСан 3Г бонд, дамжуулан зээл	(52.0)	(52.4)	0.4
Хүнс, хөдөө аж ахуйн сайд	Тариалан эрхлэлтийг дэмжих сан	(24.0)	-	(24.0)
Хууль зүйн сайд	Банк, хадгаламж зээлийн хоршооны ажлын алба	(22.2)	-	(22.2)
Сангийн сайд	Төлөгдөх зээл /4 арга хэмжээ/	(59.7)	(20.3)	(39.4)
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн дүн		(61.5)	20.9	(40.6)

1.4.21. Тайлант онд БСШУС болон Хөдөлмөрийн сайдын төсвийн багцад нийт 36.8 тэрбум төгрөгийн зээлийг дамжуулан зээлдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 29.2 тэрбум төгрөг, харин БХБС, ЭХС-ын төсвийн багцад гадаад эх үүсвэрээс нийт 22.5 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 34.4 тэрбум төгрөгт хүрч 11.9 тэрбум төгрөгөөр хэтэрчээ. Мөн Ерөнхий сайд, ЗТС-ын төсвийн багцад нийт 6.8 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэл гараагүй байна.

1.4.22. Улсын төсөвт буцаан төвлөрүүлэх зээлийн төлөвлөгөөг 85.2 тэрбум төгрөгөөр буюу 54.0 хувиар дутуу биелүүлсэн байна. Тухайлбал,

Сангийн сайд-ТЕЗ:

- Улсын төсвөөс аж ахуйн нэгж болон төсөвт байгууллагад өмнөх онуудад дамжуулан зээлдүүлсэн зээлээс 39.4 тэрбум төгрөг,

Хүнс, хөдөө аж ахуйн сайд-ТЕЗ:

- ТЭДС-гаас Монгол Улсыг хөгжүүлэх санд төлөх улаан буудайн өрийн үлдэгдэл 24.0 тэрбум төгрөг,

Хууль зүйн сайд-ТЕЗ:

- Хадгаламж зээлийн хоршоодод мөнгөө хадгалуулсан иргэдэд учирсан хохиролд улсаас олгосон зээлийн 22.2 тэрбум төгрөгийн авлага хуульд орсон өөрчлөлтийн улмаас эргэн төлөгдөх найдваргүй болсон байна.

БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ ТӨСӨВ

2.1 Улсын төсвийн орлого

Экспорт, импортын бууралтаас шалтгаалан төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна /хүснэгт №12/

2.1.1. 2015 онд Улсын төсвийн орлого ба тусламжийн дүнг 4,032.1 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3,834.0 тэрбум төгрөгийн орлого олж, төлөвлөгөө 95.1 хувийн биелэлттэй буюу 198.1 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь эрдэс бүтээгдэхүүний үнэ, экспорт импортын бууралтаас шалтгаалсан байна.

Үзүүлэлт	2012 гүйц	2013 гүйц	2014 гүйц	2015 гүйц
ДНБ-ий бодит өсөлт /хувь/	12.3	11.6	7.4	2.3
Экспорт /сая ам.доллар/	4,384.6	4,272.7	5,614.3	4,669.5
Импорт /сая ам.доллар/	6,738.4	6,354.7	5,253.7	3,797.5
Ам.долларын дундаж ханш /төг/	1,257.1	1,523.9	1,818.1	1,970.7

2.1.2. 2015 оны Улсын төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

/хүснэгт №13/

/тэрбум төгрөг/

Төсвийн орлогын ангилал, зүйл	2015 он			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,032.1	3,834.0	-198.1	95.1
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	2.3	2.3	-	100.0
1. ХХС – АМНАТ	2.3	2.3	-	100.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,029.8	3,831.7	-198.1	95.1
А. УРСГАЛ ОРЛОГО	3,743.7	3,612.5	-131.2	96.5
I. ТАТВАРЫН ОРЛОГО	3,041.4	2,943.4	-98.0	96.8
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	518.8	688.5	169.7	132.7
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,198.6	1,049.6	-149.0	87.6
Онцгой албан татвар	644.3	592.3	-52.0	91.9
Тусгай зориулалтын орлого	11.0	11.8	0.8	107.3
Гаалийн албан татвар	329.2	320.6	-8.6	97.4
Бусад татвар	339.4	280.6	-58.8	82.7
II. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	702.3	669.1	-33.2	95.3
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	58.6	15.8	-42.8	26.9
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	227.5	203.4	-24.1	89.4

2.1.3. Тайлант онд татварын орлого төлөвлөсөн хэмжээнээс 98.0 тэрбум, өмнөх оны гүйцэтгэлээс 176.2 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

2.1.4. Улсын төсөвт төвлөрсөн нийт татварын орлогын 17.9 хувийг “Оюутолгой” ХХК, 11.8 хувийг “Эрдэнэт үйлдвэр” ХХК, 4.0 хувийг “АПУ” ХХК, 3.7 хувийг “Монгол Улсын Хөгжлийн банк”, 1.7 хувийг Спиртбалбурам, 1.3 хувийг “Монголын алт МАК” ХХК, “Монголтамхи со” ХХК, 1.1 хувийг “Энержи ресурс” ХХК тус тус бүрдүүлсэн байна.

2.1.5. Тайлант онд “Оюутолгой” ХХК 205.8 мянган тн зэс, 21.5 тн алт, 38.4 тн мөнгө агуулсан 877.0 мянган тн зэсийн баяжмал борлуулж, төсөвт нийт 526.3 тэрбум төгрөгийн татвар төлсөн бол “Эрдэнэт үйлдвэр” ХХК 127.1 мянган тн зэс агуулсан 595.0 мянган тонн зэсийн баяжмал, 2,477.0 тн молибдены баяжмал үйлдвэрлэж, төсөвт 346.1 орчим тэрбум төгрөгийн татварын орлогыг төвлөрүүлсэн байна.

2.1.6. Татварын орлогын 35.7 хувийг НӨАТ, 23.4 хувийг ААНОАТ, 20.1 хувийг онцгой татвар, 10.9 хувийг гаалийн татвар, 9.9 хувийг бусад татвар бүрдүүлж байна.

2.1.7. Нэмэгдсэн өртгийн албан татвар НӨАТ-аар улсын төсөвт 2015 онд 1,198.6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1,049.6 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 149.0 тэрбум төгрөгөөр тасарчээ. НӨАТ-ын 46.0 хувийг дотоодын барааны, 54.0 хувийг импортын барааны татвар эзэлж байна.

2.1.8. Тайлант онд дотоодын барааны НӨАТ-аар 482.7 тэрбум төгрөг төвлөрсөн нь өмнөх оны гүйцэтгэлээс 67.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

2.1.9. НӨАТ-ын тайлангийн сүүлийн 5 жилийн судалгаагаар тус тайланг ирүүлбэл зохих татвар төлөгчдийн тоо жилд дунджаар 17.3 хувиар өссөн байна. Тайлант онд 32.9 мянган аж ахуйн нэгж байгууллагын 84.2 хувь нь тайлан ирүүлснээс 28.9 хувь буюу 8.0 мянган татвар төлөгч үйл ажиллагаа явуулаагүй, тайлангаарх илүү, дутуу ногдлын зөрүүгээр нийт 507.6 тэрбум төгрөгийн татвар ногдуулж, 223.9 тэрбум төгрөгийн татварын дутуу төлөлттэй байна.

2.1.10. 2015 онд импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлогоор 566.9 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөө 56.3 тэрбум төгрөгөөр тасарсан нь импортын хэмжээ өмнөх оноос 22.1 хувиар буюу 2,113.6 тэрбум төгрөгөөр буурсантай холбоотой байна.

2.1.11. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар. ААНОАТ-ын орлого өмнөх онд 621.2 тэрбум төгрөгт хүрч, 79.4 хувийн гүйцэтгэлтэй байсан бол 2015 онд 518.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 688.5 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 32.7 хувиар буюу 169.7 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

2.1.12. ААНОАТ-ын 2015 оны 4 дүгээр улирлын ногдуулалт 384.0 тэрбум төгрөг байгаа нь өнгөрсөн оноос 141.3 тэрбум төгрөгөөр буурсан нь Улсын эдийн засгийн байдал өмнөх оноос буурч, урьдын адил төгрөгийн ам.доллартай харьцах ханш өмнөх оноос суларснаас аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадвар болон санхүүгийн байдал, ашигт ажиллагаа буурч, зардал, валютын ханшны зөрүүгийн алдагдал нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.1.13. Хэдийгээр ААНОАТ-ын ногдуулалт өмнөх оноос буурсан ч тайлант оны төлөвлөгөө 132.7 хувийн биелэлттэй байгаа нь татварын байгууллага аж ахуйн нэгжүүдийн 2015 оны татварын ногдлыг онд нь багтаан төлүүлэх болон өр барагдуулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авснаас төлөвлөгөө давж биелсэн байна.

2.1.14. Сүүлийн 5 жилийн судалгаагаар аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөгчдийн тоо жилд дунджаар 10,148 татвар төлөгчөөр буюу 11.7 хувиар өссөн ба 2011 онд татвар төлөгчдөөс хүлээн авсан ААНОАТ-ын тайлангийн 52.7 хувь нь "Х" болон алдагдалтай тайлан ирүүлж байсан бол 2015 оны жилийн эцсийн байдлаар 61.4 хувь болж 8.7 пунктээр өссөн байна. Хүснэгтээр харуулбал:

/хүснэгт №14/

Он	Тайлан ирүүлбэл зохих татвар төлөгчийн тоо	Тайлан ирүүлсэн татвар төлөгчийн тоо	Үүнээс: "Х" тайлан	Алдагдалтай тайлан	Ногдол-той тайлан	Тайлан ирүүлээгүй татвар төлөгчийн тоо	Ирц хувь
2011	73 287	62 765	23 581	9 481	29 703	10 572	85.6
2012	82 479	69 453	26 184	10 828	32 441	13 026	84.2
2013	92 791	73 700	24 319	12 369	33 945	19 091	79.4
2014	105 085	79 330	29 931	19 115	30 284	25 755	75.5
2015	113 879	83 780	33 999	17 450	32 331	30 099	73.6

*Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд суурилав.

2.1.15. 2015 онд татварын байгууллагад тайлан ирүүлсэн 83.8 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 51.5 мянган нь үйл ажиллагаа явуулаагүй болон алдагдалтай ажилласан нь ААНОАТ-ын ногдол өмнөх оноос буурахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна.

2.1.16. Онцгой албан татварын орлогоор 644.3 тэрбум төгрөг оруулахаас гүйцэтгэлээр 592.3 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө 8.1 хувиар буюу 52.0 тэрбум төгрөгөөр тасарсан нь импортын хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, ханшны хэлбэлзлийн нөлөөлөлтэй холбоотой байна.

2.1.17. Онцгой албан татварын 31.1 хувийг дотоодын барааны, 68.9 хувийг импортын барааны татвар эзэлж байна. Тайлант онд улсын төсөвт төвлөрсөн дотоодын барааны онцгой албан татварын хэмжээг харуулбал:

/хүснэгт №15/

/тэрбум төгрөг/

Улсын төсөвт төвлөрүүлсэн ОАТ	гүйцэтгэл				2015	
	2011	2012	2013	2014	төл	гүйц
Дотоодын архи, дарс	67.9	92.6	148.2	160.3	131.2	129.0
Дотоодын пиво	14.5	17.6	21.8	27.9	22.7	23.7
Дотоодын тамхи	9.9	15.7	39.6	45.7	31.3	31.8
Нийт орлого	92.3	125.9	209.6	233.9	185.2	184.5

2.1.18. 2015 онд дотоодын барааны онцгой албан татварын орлогоор 184.5 тэрбум төгрөг төсөвт төвлөрсөн нь өмнөх оны гүйцэтгэлээс 49.4 тэрбум төгрөгөөр дутуу байна.

/хүснэгт №16/

/тэрбум төгрөг/

2.1.19. Импортын барааны онцгой албан татварын орлогоор нийт 459.1 тэрбум төгрөгийн орлого оруулахаас гүйцэтгэлээр 407.8 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөө 11.2 хувиар буюу 51.3 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлсэн импортын ОАТ	2014		2015	
	гүйц	төл	гүйц	төл
Автобензин, дизелийн түлш	22.1	320.1	279.1	320.1
Суудлын автомашин	90.3	52.1	43.5	52.1
Импортын архи, тамхи	100.1	81.1	80.5	81.1
Импортын пиво	7.9	5.8	4.7	5.8
Нийт орлого	220.4	459.1	407.8	459.1

2.1.20. Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар Өмнөх онд 22.1 тэрбум төгрөг төвлөрч байсан бол тайлант онд 320.1 тэрбум төгрөг төвлөрөхөөр тооцож, гүйцэтгэлээр 279.1 тэрбум төгрөг төвлөрсөн автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хэмжээ нэмэгдсэнтэй¹⁷ холбоотой байна.

2.1.21. Гаалийн албан татвар 2015 онд гаалийн албан татвараар 329.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 320.6 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөө 2.6 хувиар буюу 8.6 тэрбум төгрөгөөр тасарсан нь импортын хэмжээ буурснаас шалтгаалсан байна.

2.1.22. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр Тайлант онд нийт 254.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 180.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөгөө 73.7 тэрбум төгрөгөөр буюу 29.0 хувиар дутуу биелсэн байна.

2.1.23. Тусгай зориулалтын орлого 2015 онд 1.1 сая тонн автобензин, дизелийн түлш импортлож автобензин, дизелийн түлшний албан татварын орлогоор 11.8 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн нь 107.3 хувийн биелэлтэй байна.

2.1.24. Бусад татвар (төлбөр, хураамж) Уг татвараар нийт 339.4 тэрбум төгрөгийн орлого орохоос гүйцэтгэлээр 280.6 тэрбум төгрөгийн орлого олж, төлөвлөснөөс 17.4 хувь буюу 58.8 тэрбум төгрөгийн орлого дутуу төвлөрсөн байна.


¹⁷ ЗГ-ын 2014 оны 24 дүгээр тогтоолоор автобензин, дизелийн түлшний тонн тутамд 30.0 мянган төгрөгийн татвар авахаар байсан бол ЗГ-ын 2015 оны 18 дугаар тогтоолоор автобензинд 270-400.0 мянга, дизелийн түлшинд 390-520.0 мянган төгрөгийн татвар авахаар болсон байна.

Татварын бус орлого төлөвлөсөн хэмжээнээс 76.0 тэрбум төгрөгөөр дутуу байна

/график №6/

2.1.25. 2015 онд татварын бус орлогоор 760.9 тэрбум төгрөг төвлөрөхөөс гүйцэтгэлээр 684.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь өмнөх оны гүйцэтгэлээс 218.2 тэрбум төгрөгөөр, төлөвлөгөөнөөс 76.0 тэрбум төгрөгөөр дутуу байна.

2.1.26. Татварын бус орлогын бүтцийг графикаар харуулбал:



2.1.27. Татварын бус орлого тасарсан нь дараах орлогуудын төлөвлөгөө биелээгүйтэй холбоотой байна. Үүнд:

- Ногдол ашгийн орлого Тус орлогоор 22.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 9.1 тэрбум төгрөг төвлөрч төлөвлөснөөс 13.4 тэрбум төгрөгөөр дутуу байгаа нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн 2015 оны санхүүгийн тайлангаарх санхүүгийн үр дүн, ашиг төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй,
- Өмч хувьчлалын орлогоор 58.6 тэрбум төгрөг оруулахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 15.8 тэрбум төгрөг төвлөрсөн нь “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр ЗГ-т өргөн барьсан боловч “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл” нь анх өргөн барьсан хувилбараас өөрчлөгдсөн,
- Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан 2.3 тэрбум төгрөгийн орлого орж төлөвлөснөөс 0.7 тэрбум төгрөгийг дутуу төвлөрүүлсэн нь энэ хэмжээний авлагыг барагдуулаагүй,
- Цагдаагийн ерөнхий газар жолооны үнэмлэхний бэлдэц нийлүүлэх тендерийн¹⁸ үед маргаан үүссэнээс хугацаа алдаж, оны сүүлийн саруудад жолооны үнэмлэх хэвлэгдэж гарсан,
- Барилга, хот байгуулалтын яам бусад орлогын төлөвлөгөө 189.7 сая төгрөгөөр тасарсан нь эдийн засгийн хүндрэлийн улмаас хөрөнгө оруулалтын ажил буурсан,
- Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар бусад орлогын төлөвлөгөө 496.2 сая төгрөгөөр тасарсан нь орон нутгийн хөрөнгө оруулалтын ажил багассантай холбоотой байна.

2.1.28. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль¹⁹ хэрэгжих хугацаанд нийт 33.8 их наяд төгрөгийн хөрөнгө, орлого ил болж, 7.5 их наяд төгрөгийн татвар болон 2.4 их наяд төгрөгийн торгууль, алдангийг тус тус чөлөөлсөн байна.

2.2 Улсын төсвийн зарлага

Улсын төсвийн зарлага нийт дүнгээр хэтрээгүй ч зарим зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 20.7-204.7 тэрбум төгрөгөөр өссөн байна

2.2.1. Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн зарлагыг 5,603.3 тэрбум төгрөгөөр анх баталж, 2 удаа тодотгол хийсэн ба Төсвийн тухай хуульд 2015 оны 10 дугаар сарын 30-нд оруулсан өөрчлөлтөөр 5,218.5 тэрбум төгрөгөөр баталсан нь анхны дүнгээс 6.9 хувь буюу 384.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.

¹⁸ 2015 оноос өмнө жолооны үнэмлэхний бэлдэцийг тендер зарлалгүй шууд нийлүүлдэг байсан.

¹⁹ Албан татвар ногдох орлого, орлогоос бусад албан татвар ногдох зүйл, НДШ ногдох орлогыг 2015.04.01-ний өдрөөс өмнөх хугацаанд нуун дарагдуулсан боловч энэ хуулийн 3.1-д заасан хугацаанд сайн дурын үндсэн дээр ил болгож, санхүүгийн болон албан татварын, НДШ-ийн тайланг шинээр гаргаж харьяалах татварын алба, НД-ын байгууллагад сайн дурын үндсэн дээр мэдүүлсэн

2.2.2. 2015 онд улсын төсвийн нийт зарлагыг 5,218.5 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4,996.9 тэрбум төгрөгт хүрсэн нь 221.6 тэрбум төгрөгөөр бага байна.

2.2.3. ЗГ-аас баталсан тогтоолуудын ²⁰ дагуу бүх шатны төсөвт байгууллагуудын үр ашиггүй зардлыг тэвчих, орлогын бүрдүүлэлттэй уялдуулан зарим зардлын санхүүжилт болон зарцуулах эрхийг бууруулах шаардлага үүссэнээр урсгал зардлыг 214.7 тэрбум, дотоод эх үүсвэрээс олгогдох хөрөнгийн зардлыг 155.1 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс дутуу санхүүжүүлсэн байна.

/хүснэгт №17/		/тэрбум төгрөг/			
Эдийн засгийн ангилал	2014 оны гүйцэтгэл	2015 он төлөв	2015 он гүйцэт		Зөрүү
			гүйцэт	Зөрүү	
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	5,229.2	5,218.5	4,996.9	221.6	
Урсгал зардал	3,910.2	4,240.1	4,025.4	214.7	
Бараа, ажил үйлчилгээний зардал	1,536.0	1,732.6	1,639.6	93.0	
Хүү	438.3	663.8	663.7	0.1	
Татаас	116.1	76.2	47.3	28.9	
Урсгал Шилжүүлэг	1,819.8	1,767.5	1,674.8	92.7	
Хөрөнгийн зардал	1,238.8	1,039.7	950.7	89.0	
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	80.1	-61.3	20.8	-82.1	

2.2.4. Нийт зарлагын 80.6 хувь буюу 4,025.4 тэрбум төгрөгийг урсгал зардалд, 19.0 хувь буюу 950.7 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардалд, 0.4 хувь буюу 20.8 тэрбум төгрөгийг эргэж төлөгдөх цэвэр зээлд зарцуулсан байна.

2.2.5. Нийт зарлагын 23.3 хувийг Сангийн сайд, 21.2 хувийг БСШУС, 12.8 хувийг ЭМСС, 8.4 хувийг ХЗС, 8.1 хувийг ХАХНХС, 4.9 хувийг ЗТС, 4.4 хувийг БХС, 2.7 хувийг Хөдөлмөрийн сайд, 14.2 хувийг бусад ТЕЗ-дын зарлага эзэлж байна.

2.2.6. ЗТС, БХБС-ын багцын төсвөөс бусад ТЕЗ-дын төсвийн зардал хэтрээгүй буюу 71.6-99.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.2.7. Харин ЗТС, БХБС-ын төсөв 9.7-41.6 хувиар хэтэрсэн нь гадаад төслийн зээлийн санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн тухайн жилийн ашиглалтыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс шалтгаалсан байна. Тухайлбал,

- ЗТС-ын төсөв 65.9 тэрбум төгрөг буюу 41.6 хувиар хэтэрсэн нь олон улсын нисэх буудал барих төслийн барилгын ажлыг 2017 онд дуусгах зорилгоор хөрөнгө оруулалтын ажлыг урьдчилан гүйцэтгэж, гадаад зээлийн эх үүсвэрээс 127.4 тэрбум төгрөгийг авч ашигласантай холбоотой байна.
- БХБС-ын төсөв 5.6 тэрбум төгрөг буюу 9.7 хувиар хэтэрсэн нь Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн санхүүжилтийг улсын төсөвт бодитой тусгаагүй, 2014 оны зөвлөх үйлчилгээний зардлын гүйцэтгэлийг тайлант онд олгосон, барилгын ажлын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс илүү дүнтэй гарсан зэрэг шалтгаантай байна.

2.2.8. Улсын төсвийн зарлага нийт дүнгээр хэтрээгүй боловч зарим зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 20.7-204.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

/хүснэгт №18/		/тэрбум төгрөг/			
Эдийн засгийн ангилал	2014 он Гүйц	2015 он Төлөв	2015 он Гүйц	Зөрүү	
				Өмнөх оны гүйц-ээс	Төлөвлөснөөс
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	866.1	957.5	948.1	82.0	9.4
Гадаадын зээлийн үйлчилгээний төлбөр	171.5	192.2	192.2	20.7	-
Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр	266.8	471.6	471.5	204.7	0.1

2.2.9. Төрийн албан хаагчдын цалинг 2014 оноос үе шаттайгаар нэмэгдүүлсэн, хуваарийн дагуу төлөх гадаад, дотоод зээлийн хүү өссөн нь тухайн зардлууд нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

²⁰ ЗГ-ын 2015 оны 109 дүгээр тогтоолоор "Монгол Улсын 2015 оны төсвийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай", 2015 оны 377 дугаар тогтоолоор "Монгол Улсын 2015 оны төсвийн тодотголыг УИХ-д өргөн мэдүүлэн батлуулах хүртэл хугацаанд авах зарим арга хэмжээний тухай", 2014 оны 147 дугаар тогтоолоор "Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай"

2.2.10. Улсын төсвийн зарлагыг эдийн засгийн ангиллаар авч үзэхэд бүлгийн дүнгээр хэтрээгүй боловч зочин төлөөлөгч хүлээн авах зардалд 277.5 сая төгрөгийг төлөвлөсөн хэмжээнээс илүү зарцуулсан байна.

2.2.11. “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын хэрэгжилт зарим ТЕЗ-ийн хүрээнд хангалтгүй байна. Тухайлбал,

- УУС-ТЕЗ: Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлгийн зардлын төлөвлөгөөнд хэвлэл мэдээлэл, сурталчилгааны зардалд 60.0 сая төгрөгийг төлөвлөж батлагдсан гүйцэтгэлээр 46.7 сая төгрөгийг зарцуулсан, тус яам Монгол Ньюс медиа ХХК –тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж 11.0 сая төгрөгийг хэвлэл мэдээллийн зардалд зарцуулсан боловч нотлох баримтгүй, урамшуулал олгох төсөвгүй байхад үндсэн цалинг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцож 146.9 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон, “Мон ЭБС” ахмадын нэгдсэн холбоонд 15.0 сая төгрөгийг тэтгэмжийн зардлаас санхүүжүүлсэн,
- ХАХНХС-ТЕЗ: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 177.5 сая, гадаад томилолт 24.9 сая төгрөгөөр тус тус хэтэрч, мөн яамны харьяа агентлаг, төвийн дэд дарга, орлогч дарга, зөвлөхийн орон тоог 2015 оны 1 дүгээр сард 12-оор бууруулсан ч 5 дугаар сараас эхлэн бүтцийн өөрчлөлтөөр дахин орон тоог нэмэгдүүлсэн,
- БХБС-ТЕЗ: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 331.8 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн байна.

2.2.12. Улсын төсвөөс төрийн өмчит болон хувийн хэвшлийн байгууллагад дараах зориулалтаар нийт 368.9 тэрбум төгрөгийн татаас, шилжүүлэг олгожээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын сангийн төр хариуцах иргэдийн тэтгэвэр, тэтгэмжид 292.6 тэрбум,
- Арьс шир, ноос ноолуур, улаан буудайн урамшуулалд 53.0 тэрбум,
- Эрчим хүчний алдагдлыг бууруулахад 20.1 тэрбум,
- Агаарын бохирдлыг бууруулахад 2.1 тэрбум,
- Бүх нийтийн үүргийн үйлчилгээний санд 1.1 тэрбум

2.2.13. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс авсан судалгаагаар улсын хэмжээнд 2015 онд төрийн байгууллага, ажилтны буруутай үйл ажиллагааны улмаас төрийн албан хаагчдыг ажлаас үндэслэлгүйгээр халсан, ажилгүй байсан хугацааны цалинг олгох талаар Иргэний хэргийн шүүхээс 683.5 сая, Захиргааны хэргийн шүүхээс 389.2 сая, нийт 1,072.7 сая төгрөгийг төсвөөс гаргуулахаар шийдвэрлэсний дагуу 509.7 сая төгрөгийг төлбөр авагчдад олгожээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байна

2.2.14. Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулиар 33 ТЕЗ-ийн үндсэн чиг үүрэгт хамаарах 94 хөтөлбөрийн 331 арга хэмжээг хүрэх үр дүн, зорилтот түвшинээр нь баталсан байна.

2.2.15. ТЕЗ-дын төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээний 26.9 хувь буюу 89 нь дутуу, 2.4 хувь буюу 8 нь хэрэгжээгүй байна.

2.2.16. Зарим ТЕЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт төсөвт хөрөнгө төлөвлөгдөөгүй шалтгаанаар хэрэгжээгүй байна. Тухайлбал,

- ЗТС-ТЕЗ: Богдхан уулын урдуур шинэ төмөр зам барих зураг төсөл боловсруулах, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын I, II үе шатны 1800 км шинэ төмөр зам барих зураг төсөл боловсруулах, Ухаа худаг-Гашуун сухайт чиглэлийн төмөр зам барих,
- БХБС-ТЕЗ: Геодези, зураг зүйн өндрийн сүлжээний давтан болон шугамын хэмжилт хийх, БОНХАЖС-ТЕЗ: Байгаль орчны хяналт-шинжилгээний лабораторийг шинэчлэх,
- Шадар сайд-ТЕЗ: Стандартчилал, хэмжил зүйн ур чадварын сорилтод хамруулах лабораторийн тоон үзүүлэлт зэрэг хөтөлбөр тус тус хэрэгжээгүй байна.

2.2.17. Мөн хүн амын боловсрол, соёл, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн талаар ТЕЗ-дын хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгдсөн олон арга хэмжээний хүрэх үр дүнгийн үзүүлэлт дутуу хэрэгжсэн нь нийгмийн салбарын ажлын үзүүлэлт санхүүжсэн төсөвтэй нь харьцуулахад хангалтгүй байгаатай холбоотой байна.

2.3 Улсын төсвийн тэнцэл

2.3.1. 2015 онд Улсын төсвийн нийт тэнцлийг 1,188.8 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 1,165.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

2.3.2. 2015 оны Улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор 2,571.9 тэрбум төгрөгийн ЗГ-ын үнэт цаас арилжаалж, 500.7 тэрбум төгрөгийн зээл гадаадаас авч ашиглажээ.

2.3.3. Дээрх эх үүсвэрүүдээс ЗГ-ын үнэт цаасны эргэн төлөлтөд 1,880.1 тэрбум, ЗГ-ын гадаад зээлийн эргэн төлөлтөд 126.4 тэрбум төгрөгийг зарцуулсан ба Хөгжлийн банкны эх үүсвэрээс улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлсэн 433.6 тэрбум, ХХС болон улсын төсөв хоорондын урьдчилгаа төлбөрөөс орлогод суутган тооцсонтой холбоотой 240.1 тэрбум төгрөгийг тус тус авлагаар бүртгэж, тайлант хугацаанд харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл 94.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН 2015 ОНЫ ТӨСӨВ

3.1 Орон нутгийн төсвийн орлого

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө биелжээ

3.1.1. Тайлант онд орон нутгийн төсвийн нийт орлого ба тусламжийн дүнг 2,073.2 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,033.8 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 39.4 тэрбум төгрөгөөр, өмнөх оны гүйцэтгэлээс 104.6 тэрбум төгрөгөөр дутуу байна.

/хүснэгт №19/				/тэрбум төгрөг/	
Орлогын нэр		2014 он гүйц	төл	2015 оны гүйц	зөрүү
УРСГАЛ ОРЛОГО		809.2	825.6	818.8	(6.8)
Татварын орлого		696.3	733.3	734.4	1.1
Татварын бус орлого		112.9	92.3	84.4	(7.9)
ХӨРӨНГИЙН ОРЛОГО		2.2	25.7	39.4	13.7
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО		1,327.0	1,221.9	1,175.6	(46.3)
Нийт орлого ба тусламжийн дүн		2,138.4	2,073.2	2,033.8	(39.4)

3.1.2. Орон нутгийн төсвийн орлогын 36.1 хувийг татварын, 4.1 хувийг татварын бус, 2.0 хувийг хөрөнгийн, 57.8 хувийг тусламжийн орлого бүрдүүлсэн байна.

3.1.3. Орон нутгийн татварын орлого 0.2 хувиар буюу 1.1 тэрбум, хөрөнгийн орлого 53.3 хувиар буюу 13.7 тэрбум төгрөгөөр давж биелсэн ба харин татварын бус орлого 8.6 хувиар буюу 7.9 тэрбум, тусламжийн орлого 3.8 хувиар буюу 46.3 тэрбум төгрөгөөр тус тус тасарчээ.

3.1.4. Орон нутгийн төсвийн нийт орлогын 2015 оны батлагдсан төсвийг өмнөх онтой харьцуулбал 3.1 хувиар буурсан ба орон нутгийн ИТХ-аас орон нутгийн төсөвт олон удаа өөрчлөлт оруулах, аймгийн төсвийг нэгтгэхдээ сумдын ИТХ-ын хурлаар төсвийн тодотгол, хийсэн шийдвэрээ аймагт хүргүүлэхгүй байх зөрчил давтагдсан хэвээр байна. Тухайлбал,

- Орхон аймгийн ИТХ төсвийг 3 удаа тодотгож, орон нутгийн суурь орлогыг 3,552.6 сая төгрөг, суурь зарлагыг 1,350.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан,
- Төв аймгийн ИТХ-ын 2015.12.04-ний өдрийн 11-р хуралдаанаар төсвийн тодотголыг хийхдээ төсвийн орлогын төлөвлөгөөг давж биелүүлсэн буюу тасарсан орлогоор тодотгосон,
- Сэлэнгэ аймаг халамжийн тэтгэмжийг бодит тооцоо судалгаан дээр үндэслэн төлөвлөөгүйгээс жилийн эцэст бууруулж өөрчилсөн, аймаг, сумдын төсвийг тус бүр 3-5 удаа тодотгон төсвийн орлого, зарлагыг үндэслэлгүй төлөвлөж баталсан,
- Баян-Өлгий аймгийн ИТХ-аас орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг анх баталснаас 746.6 сая төгрөгөөр бууруулсан, орлогын төлөвлөгөөнд 3 удаа, зарлагын төлөвлөгөөнд 4 удаа өөрчлөлт оруулж тодотгосон,
- Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолоор сумдын суурь орлого, зарлагын хэмжээг тооцохгүйгээр санхүүгийн дэмжлэгийг баталсан, аймгийн төсвийн орлогын нэгтгэлийг хийхдээ сумдын ИТХ-ын тогтоолыг бүрэн аваагүйгээр орлогын төлөвлөгөөг нэгтгэсэн,
- Хөвсгөл аймгийн ИТХ төсөв батлахдаа хувьцааны ногдол ашиг төвлөрүүлэхээр 104.2 сая төгрөгийг нэмж төлөвлөсөн нь төсвийн төсөлд зарлагын эх үүсвэрийг 104.2 сая төгрөгөөр дутуу тооцож зөрүүгээр улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авахад хүргэсэн,
- Нийслэлийн төсөвт 3 удаа тодотгол хийсэн ба НИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 33/36 дугаар тогтоолоор төсвийн орлогыг анх баталсан төлөвлөгөөнөөс 6,196.2 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

3.1.5. Аймаг, нийслэлийн төсвийн 2015 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

/хүснэгт №20/

/тэрбум төгрөг/

Аймаг нийслэлийн нэр	Төсвийн орлого				Аймаг нийслэлийн нэр	Төсвийн орлого			
	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Архангай	6.7	8.0	1.3	119.1	Сүхбаатар	9.7	9.1	(0.6)	94.2
Баян-Өлгий	5.6	6.7	1.1	119.9	Сэлэнгэ	15.7	14.7	(1.0)	93.3
Баянхонгор	6.8	7.3	0.5	107.6	Төв	13.0	13.7	0.7	105.3
Булган	17.5	18.1	0.6	103.2	Увс	8.1	7.4	(0.7)	91.3
Говь-Алтай	6.6	6.0	(0.5)	91.8	Ховд	10.5	8.7	(1.8)	83.1
Дорноговь	16.9	15.9	(1.0)	94.1	Хөвсгөл	9.8	9.6	(0.2)	97.8
Дорнод	13.5	14.2	0.6	104.7	Хэнтий	8.7	9.4	0.7	107.8
Дундговь	4.1	4.8	0.6	115.6	Дархан-Уул	15.7	16.0	0.3	102.1
Завхан	6.2	6.4	0.2	103.3	Улаанбаатар	543.2	560.1	16.8	103.1
Өвөрхангай	9.9	11.2	1.3	113.0	Орхон	44.0	41.2	(2.8)	93.6
Өмнөговь	74.3	65.4	(8.9)	88.0	Говьсүмбэр	4.6	4.4	(0.2)	94.9
Бүгд дүн						851.3	858.3	7.0	100.8

3.1.6. Татварын орлогын төлөвлөгөөг дараах 10 аймаг нийт 17.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна. Тухайлбал,

- Говь-Алтай аймаг 542.2 сая төгрөг: Цалин хөлс, түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, газрын төлбөр, ойн нөөц ашигласны төлбөр, байгалийн ургамал ашигласны төлбөр, өмч хувьчлалын орлого тасарсан,
- Дорноговь аймаг 998.1 сая төгрөг: Уул уурхайн компаниуд үйл ажиллагаагаа тогтмол явуулаагүй, Замын-Үүд боомтоор зорчих иргэдийн тоо цөөрч, ачаа болон зорчигч тээвэрлэгч автомашины тоо өмнөх оноос буурсан,
- Өмнөговь аймаг 8,918.3 сая төгрөг: Татварын газар, Санхүү төрийн сангийн хэлтэс хоорондын орлого зөрүүтэй тайлагнагдсанаас, мөн уул уурхайн компаниудын үйл ажиллагаа зогсонги байдалд орсон,
- Сүхбаатар аймаг 564.7 сая төгрөг: Газрын төлбөрийн орлого дутуу төвлөрсөн нь дуудлага худалдаа зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй, “Монгол Жүюаньли” ХХК 49,7 сая төгрөгийн татварын өрөө барагдуулаагүй, “Эм Эл Цахиурт овоо” ХХК зах зээл дээр төмрийн хүдрийн үнэ унасантай холбоотойгоор үйлдвэрлэлээ эхлүүлээгүй,
- Сэлэнгэ аймаг 1,048.5 сая төгрөг: Оны эцэст 827 татвар төлөгчийн 3,128.2 сая төгрөгийн ХХОАТ-ын, 134.8 сая төгрөгийн АТБӨЯХАТ-ын авлагатай тайлагнагдсан,
- Увс аймаг 707.6 сая төгрөг: Татварын 9 нэр төрлийн орлого тасарсан,
- Ховд аймаг 1,777.5 сая төгрөг: Байгалийн ургамал ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, ус рашаан ашигласны төлбөрийн орлого тасарсан,
- Хөвсгөл аймаг 226.2 сая төгрөг, Орхон аймаг 2,814.7 сая төгрөг: Хувь хүний орлогын албан татвар, АТБӨЯХАТ, газрын төлбөр, дуудлага худалдааны орлого тасарсан,
- Говьсүмбэр аймаг 236.1 сая төгрөг: Үл хөдлөх хөрөнгийн албан татвар, түрээсийн орлого, ус рашаан ашигласны төлбөр тус тус тасарсантай холбоотой байна.

3.1.7. Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулиар улсын төсвөөс орон нутагт 165.1 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгох, ОНХНС-ийн эх үүсвэрт Өмнөговь, Орхон аймгаас 21.7 тэрбум төгрөг төвлөрүүлэх, ОНХНС-гаас орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 127.2 тэрбум төгрөгөөр тус тус баталсан байна.

3.1.8. 2015 онд улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээр 18 аймагт 160.5 тэрбум төгрөг олгож, ОНХНС-д Орхон аймаг төлөвлөгөөт 3.0 тэрбум төгрөгийг бүрэн, Өмнөговь аймаг төлөвлөснөөс 8.7 тэрбум төгрөгөөр дутуу буюу 10.0 тэрбум, нийт 13.0 тэрбум төгрөг төвлөрч, ОНХНС-гаас орон нутгийн хөгжлийн санд 106.0 тэрбум төгрөгийг олгожээ.

3.2 Орон нутгийн төсвийн зарлага

Төсвийг үр ашигтай, арвиалан хэмнэлттэй төлөвлөж зарцуулах зарчмыг баримтлаагүй байна

хүснэгт №21/		/тэрбум төгрөг/				
3.2.1. Орон нутгийн төсвийн нийт зарлага 2,079.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 10.3 хувь буюу 238.7 тэрбум төгрөгөөр санхүүжжээ.	ҮЗҮҮЛЭЛТ	2014 он гүйцэт	Төлөв	2015 он		
			Гүйц	Зөрүү	Хувь	
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		2,129.6	2,317.8	2,079.1	(238.7)	89.7
Урсгал зардлын дүн		1,606.6	1,742.0	1,647.2	(94.8)	94.6
Бараа үйлчилгээний зардал		1,246.9	1,362.6	1,300.1	(62.5)	95.4
Татаас ба урсгал шилжүүлэг		359.8	379.4	347.1	(32.3)	91.5
Хөрөнгийн зардал		523.0	564.9	429.8	(135.1)	76.1
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл		-	10.9	2.1	(8.8)	19.3

3.2.2. Нийт зарлагын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад 50.5 тэрбум төгрөгөөр буюу 2.4 хувиар буурсан байна.

3.2.3. Орон нутгийн нэгдсэн төсвийн нийт зарлагын дүнд урсгал зардал 79.2 хувийг, хөрөнгийн зардал 20.7 хувийг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 0.1 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны гүйцэтгэлээс урсгал зарлага 40.6 тэрбум, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 2.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, харин хөрөнгийн зардал 93.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.

3.2.4. Аймаг, нийслэлийн төсвийн 2015 оны зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

хүснэгт №22/					/тэрбум төгрөг/				
Үзүүлэлт	Зарлага				Үзүүлэлт	Зарлага			
	Төл	Гүйц	Зөрүү	Хувь		Төл	Гүйц	Зөрүү	Хувь
Архангай	62.6	60.3	2.3	96.3	Сүхбаатар	48.6	45.8	2.8	94.3
Баян-Өлгий	68.2	64.8	3.4	95.1	Сэлэнгэ	67.1	62.8	4.3	93.5
Баянхонгор	60.6	57.8	2.8	95.4	Төв	69.3	65.1	4.2	94.0
Булган	54.2	50.9	3.3	93.8	Увс	62.5	58.0	4.5	92.7
Говь-Алтай	58.0	52.7	5.2	91.0	Ховд	60.2	56.7	3.5	94.1
Дорноговь	45.8	43.4	2.4	94.7	Хөвсгөл	86.0	81.1	4.9	94.3
Дорнод	53.4	50.6	2.8	94.7	Хэнтий	55.3	53.0	2.3	95.8
Дундговь	42.8	39.8	3.0	93.0	Дархан-Уул	54.4	50.8	3.6	93.4
Завхан	55.3	54.4	0.9	98.4	Улаанбаатар	1,032.3	883.8	148.5	85.6
Өвөрхангай	71.8	67.9	3.9	94.6	Орхон	84.6	70.2	14.4	83.0
Өмнөговь	108.1	81.5	26.6	75.4	Говьсүмбэр	16.9	14.9	1.9	88.5
Бүгд дүн						2,317.8	2,066.2		

3.2.5. Тайлант онд орон нутгийн төсвийн урсгал зардал нь өмнөх оноос 40.6 тэрбум төгрөгөөр өсч 1,647.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа ба үүнээс 828.7 тэрбум төгрөг буюу 50.3 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэл, 471.4 тэрбум төгрөг буюу 28.6 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 347.1 тэрбум буюу 21.1 хувийг татаас, урсгал шилжүүлгийн зардал тус тус эзэлж байна.

3.2.6. Хөрөнгийн зардал өмнөх оноос 93.2 тэрбум төгрөгөөр буурч 429.8 тэрбум төгрөгт хүрч, нийт зарлагын 26.1 хувийг эзэлж байгаа нь орон нутгийн дотоод эх үүсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалтын санхүүжилт буурсантай холбоотой байна. Хөрөнгийн зардалд 211.1 тэрбум төгрөг буюу 12.8 хувийг барилга байгууламж, 91.0 тэрбум төгрөг буюу 5.5 хувийг их засвар, 127.6 тэрбум төгрөг буюу 7.7 хувийг хөрөнгийн бусад зардал тус тус эзэлж байна.

3.2.7. Орон нутгийн ТЕЗ, түүний харьяа зарим байгууллагууд төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй, “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд бүрэн анхаарч ажиллаагүй байна. Тухайлбал:

- Нийслэл, дүүргийн Засаг даргын захирамжаар 22 орлогч, ИТХ-ын дэд дарга 1, ЗД-ын зөвлөх 2, ИТХ-ын даргын зөвлөх 1 хүнийг томилон цалин, урамшууллын зардалд 410.9 сая төгрөг зарцуулсан,
 - Дүүргүүд баяр ёслол, ойн арга хэмжээ тэмдэглэхэд 733.0 сая төгрөг зарцуулсан,
 - Автомашин унах эрхгүй Засаг даргын орлогч /илүү орон тооны/, алба хэлтэс, зарим дүүргийн хороодын Засаг дарга нар албан ажлын автомашин ашиглаж, нийт 101 албан тушаалтан 239.6 сая төгрөгийг тээвэр, шатахуун болон сэлбэг хэрэгслийн зардалд зарцуулсан,
 - Нийслэл, дүүргийн ИТХ-ын 265 төлөөлөгчид 6,563.6 сая төгрөгийн урамшуулал олгосон,
 - Дүүргийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр урсгал зардлуудыг санхүүжүүлэхээр төлөвлөж 123.3 сая төгрөг зарцуулсан,
 - Чингэлтэй дүүрэгт “Ногоон булан ахмадын сувилал”, “Ахмадын газар” гэсэн нэг төрлийн үйл ажиллагаа явуулдаг 2 байгууллага ажиллуулж, төсвөөс санхүүжүүлсэн,
 - Мөн дээрх дүүрэгт Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэстэй ижил чиг үүргийг хэрэгжүүлж буй нийгмийн халамж, дэмжлэгийн үйлчилгээ үзүүлэх сан /2014 оноос дүүргийн Засаг даргын шийдвэрээр/ байгуулсан,
 - Сонгинохайрхан дүүрэгт Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар болон дүүргийн дэд бүтэц, тохижилтийн хэлтэстэй давхцсан чиг үүрэг бүхий “Захиалагчийн ажлын алба” ОНӨААТҮГ-ыг шинээр байгуулсан,
- Архангай, Орхон, Баянхонгор аймаг Засаг даргын нөөц сан болон ангилагдаагүй зардлаас 11.9-59.5 сая төгрөгийг гадаад албан томилолтын зардалд зарцуулсан,
- Баян-Өлгий 1,130.6 сая, Хөвсгөл 1,216.3 сая төгрөгийг тус тус халамжийн сангийн зарцуулагдаагүй үлдэгдлээс урсгал зардалд зарцуулсан нь тухайн сангийн зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүй,
- Сэлэнгэ 159.5 сая, Говьсүмбэр 250.2 сая, Дархан-Уул 10.9 сая, Төв аймаг 196.3 сая төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан,
- Дорноговь аймаг төсвийн орлогын биелэлт хангалтгүй байснаас 229.6 сая төгрөгийг өмнөх оны чөлөөт үлдэгдлээс нэмж зарцуулсан,
- Дорнод аймгийн ЗДТГ-ын автомашины парк шинэчлэл, гадаад томилолтын зардалд нийт 199.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.2.8. 2015 онд орон нутгийн төсвийн байгууллагын албан хаагчдын тоо 93,843 байхаар батлагдсанаас 94,159-д хүрсэн нь төлөвлөснөөс удирдах ажилтан 13, гүйцэтгэх ажилтан 459-өөр тус тус хэтэрч /Сангийн яамнаас хянасан, орон нутгийн ИТХ-ын баталсан орон тооноос/, үйлчлэх ажилтан 136, гэрээт ажилтан 20 орон тоогоор дутуу байна.

3.2.9. Сангийн яамны хянаснаас дор дурдсан нэр бүхий аймаг төрийн албан хаагчдын орон тоог 55-102 хүнээр буюу нийт 623 хүнээр хэтрүүлснээр, Булган 1, Говь-Алтай 4, Увс 10, Дундговь 12, Сүхбаатар 13, Нийслэл 267, нийт 307 орон тоогоор дутуу ажилласнаар тайлагнажээ. Тухайлбал:

- Архангай 55, Баян-Өлгий 102, Сэлэнгэ 59, Ховд 31, Хэнтий аймаг 102 хүнээр орон тоог хэтрүүлсэн,
- Дархан-Уул аймаг батлагдаагүй 4 орон тоонд ажил хавсруулан ажиллуулсан, мөн шинээр Оюуны ирээдүй, Од цогцолбор сургууль, 4 цэцэрлэг, 2 гэр цэцэрлэг ашиглалтад орсноос гадна зарим нэмэгдэл орон тоотой холбоотойгоор нийт 147 орон тоо хэтэрсэн,
- Завхан аймаг хүүхдийн цэцэрлэг, сумдын эрүүл мэндийн төвийн ажиллагсдын орон тоо 30-аар нэмэгдсэн,
- Нийслэл болон Говь-Алтай, Өвөрхангай, Төв, Дундговь, Дорнод, Дорноговь, Хөвсгөл аймгийн ТЕЗ-дын ажиллагсдын орон тооны мэдээлэл зөрүүтэй байна.

3.2.10. “Орон тооны жишиг тогтоох аргачлал, орон тооны дээд жишиг норматив батлах тухай” Сангийн сайдын 2012 оны 7 дугаар сард баталсан 156 дугаар тушаалыг мөн сайдын 2012 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 204 дүгээр тушаалаар хүчингүй болгосон, зарим орон нутгийн удирдлага Засгийн газрын холбогдох тогтоолыг зөрчин орон тоог нэмэгдүүлж байгаа нь орон

нутаг дахь төсвийн байгууллагын ажиллагсдын нийт тоо төлөвлөснөөс 316-аар хэтрэхэд нөлөөлсөн байна.

3.3 Орон нутгийн төсвийн тэнцэл

3.3.1. 2015 онд орон нутгийн төсвийн нийт тэнцлийг 244.6 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 45.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь өмнөх онтой харьцуулахад 7.9 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

3.3.2. Орон нутгийн 2015 оны төсвийн нийт тэнцлийн алдагдлыг Засгийн газрын гадаад зээлээс 16.2 тэрбум төгрөгөөр, харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл 228.4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 4.4 тэрбум төгрөгийн гадаад зээл авч ашиглаж, тайлант оны эцэст орон нутгийн харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл 41.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

БҮЛЭГ 4. ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2015 ОНЫ ТӨСӨВ

4.1 Хүний хөгжил сангийн төсвийн орлого

4.1.1. Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуулиар 356.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 423.0 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөөний биелэлт 118.5 хувьтай гарчээ. Хүснэгтээр харуулбал,

/хүснэгт №23/		/тэрбум төгрөг/		
Ангилал		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1. Нийт орлогын дүн		356.9	423.0	66.1
1.1.	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	286.9	423.0	136.1
1.2.	Хувьцааны ногдол ашиг	70.0	-	-70.0
1.3	Бусад орлого	-	0.01	0.01

4.1.2. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 423.0 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 47.4 хувь буюу 136.1 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь эрдэс бүтээгдэхүүний гарц, биет хэмжээний өсөлттэй холбоотой байна.

4.1.3. Өмнөх оны хишиг, хувь олголтын зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн 6.3 сая төгрөг, хувьцаа борлуулсны орлого 51.1 сая төгрөг төвлөрсөн байна.

4.1.4. Хүний хөгжил санд “Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас 2014 оны ногдол ашгийн орлогоор 70.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцсон боловч тус компанийн хувь нийлүүлэгчдийн зөвлөл хуралдаагүй, ногдол ашиг хуваарилах шийдвэр гараагүйн улмаас дээрх орлого төвлөрөөгүй байна.

4.2 Хүний хөгжил сангийн төсвийн зарлага

4.2.1. Тайлант онд Хүний хөгжил сангаас 328.8 тэрбум төгрөг зарцуулахаар батлагдсанаас 308.4 тэрбум төгрөг зарцуулж, 93.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

/хүснэгт №24/		/тэрбум төгрөг/		
Ангилал		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1. Нийт зарлагын дүн		328.8	308.4	-20.4
1.1.	Төр хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэл	12.0	12.0	-
1.2.	Иргэдэд олгох бэлэн мөнгө	246.0	225.7	-20.3
1.2.1.	Хүүхдийн мөнгө	246.0	225.7	-20.3
1.3	ЗГ-ын бонд болон урьдчилгаа төлбөрийн хүүгийн зардал	67.4	67.3	-0.1
1.4	Хөрөнгө оруулалт	3.3	3.3	-
1.5	Бусад зардал	-	0.2	-

4.2.2. Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан 16 хүртэлх насны хүүхэд, өндөр насны тэтгэвэр авагч, хүүхдээ асарч буй эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хугацаат цэргийн албан хаагч, халамжийн тэтгэвэр авагч, их, дээд сургуулийн өдрийн ангийн суралцагчид зэрэг нийт 1.5 сая иргэдийн төрөөс хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрт 12.0 тэрбум төгрөг зарцуулсан байна.

4.2.3. Тайлант онд 0-18 насны 1,027.6 мянган хүүхдэд сар бүр олгох 20.0 мянган төгрөгийн тэтгэмжид сангаас нийт 225.7 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

4.2.4. Хүний хөгжил сангийн төсвийн дутагдлыг нөхөх, өрийг дахин санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны хүүгийн төлбөрт 67.3 тэрбум төгрөг төлж, 2015 оны эцсийн байдлаар 486.5 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаасны үлдэгдэлтэй байна.

4.3 Хүний хөгжил сангийн төсвийн тэнцэл

4.3.1. Хүний хөгжлийн сангийн 2015 оны нийт тэнцэл 28.1 тэрбум төгрөгийн ашигтай байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 114.7 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

- Тус санд УИХ-ын 2015 оны 8 дугаар тогтоолын²¹ дагуу 179.8 тэрбум төгрөгийн ЗГ-ын үнэт цаас арилжаалж, үндсэн төлбөрт²² 190.2 тэрбум төгрөг төлсөн,
- “Оюутолгой” ХХК, “Эрдэнэс МГЛ” ХХК-иас төвлөрүүлсэн урьдчилгаа төлбөрийн үлдэгдлээс дээрх компаниудын төсөвт төлөх татварын орлогын 293.0 тэрбум төгрөгийг суутган тооцсоноос 240.1 тэрбум төгрөгийг улсын төсвийн орлогод, үлдэх 52.9 тэрбум төгрөгийг ХХС-гийн орлогод тооцсон байна.

4.3.2. Тайлант оны эхэнд Хүний хөгжил сангийн харилцах дансны үлдэгдэл 33.4 тэрбум төгрөг байсан бол 2015 оны эцэст 84.8 тэрбум болж 51.4 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

БҮЛЭГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2015 ОНЫ ТӨСӨВ

5.1 Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого

5.1.1. Нийгмийн даатгалын сангийн орлогод 2015 онд 1,544.2 тэрбум төгрөг төлөвлөснөөс 1,480.5 тэрбум төгрөг төвлөрч, 95.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

5.1.2. Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуулиар шимтгэлийн орлогоор нийт 1,222.6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 1,187.9 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулж, төлөвлөгөө 2.7 хувиар буюу 34.7 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна. Орлогын төрлөөр харуулбал:

/хүснэгт №25/

/тэрбум төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Тэтгэврийн даатгал	750.7	719.1	-31.6	95.8
2	Тэтгэмжийн даатгал	85.2	81.1	-4.1	95.2
3	ҮОМШӨ-ний даатгал	108.2	109.8	1.6	101.5
4	Ажилгүйдлийн даатгал	27.8	29.8	2.0	107.2
5	Эрүүл мэндийн даатгал	250.7	248.1	-2.6	99.0
	Дүн	1,222.6	1,187.9	-34.7	97.3
6	Улсын төсвөөс санхүүжих	321.6	292.6	-29.0	91.0
	Нийт дүн	1,544.2	1,480.5	-63.7	95.9

²¹ Хүний хөгжил сангийн төсвийн цаг зуурын хүндрэлийг даван туулахад зориулан 461.1 тэрбум төгрөгийн үнэт цаасыг 2015 оны төсвийн жилд гаргаж, арилжаалахыг Засгийн газарт зөвшөөрсөн.

²² Хүний хөгжил сангийн 2012 онд гаргасан бондын төлбөр 25.0 тэрбум төгрөг, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан гаргасан 55.7 тэрбум төгрөгийн бондын төлбөр, Хөгжлийн банкны бондын төлбөрөөс 109.5 тэрбум төгрөг зэрэг нийт 190.2 тэрбум төгрөг

5.1.3. 2015 онд төрөөс хариуцдаг тэтгэврийн санхүүжилтэд улсын төсвөөс 292.6 тэрбум төгрөгийн санхүүжилт авч, хадгаламжийн хүүгээс 56.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлжээ.

5.1.4. Тайлант онд НДС-гийн нийт 839.9 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөөс 467.0 тэрбум төгрөгийг арилжааны банкинд байршуулсан нь өмнөх оноос 65.0 тэрбум төгрөгөөр буюу 1.1 дахин буурч, нийт мөнгөн хөрөнгийн 55.6 хувийг эзэлж байна.

5.2 Нийгмийн даатгалын сангийн төсвийн зарлага

5.2.1. Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуулиар зарлагыг нийт 1,546.6 тэрбум төгрөгөөр баталсан байна.

5.2.2. 2015 онд Нийгмийн даатгалын сангаас давхардсан тоогоор 5,497.9 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардалд нийт 1,541.4 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Зардлын гүйцэтгэлийг харуулбал,

/хүснэгт №26/

/тэрбум төгрөг/

	Ангилал	2015 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Тэтгэврийн даатгал	1,179.0	1,191.9	12.9	101.1
2	Тэтгэмжийн даатгал	88.8	89.5	0.7	100.8
3	ҮОМШӨ-ний даатгал	36.3	33.5	-2.8	92.3
4	Ажилгүйдлийн даатгал	25.7	23.4	-2.3	91.1
5	Эрүүл мэндийн даатгал	216.8	203.1	-13.7	93.7
	ДҮН	1,546.6	1,541.4	-5.2	99.7

5.2.3. Сангуудын зардал дараах шалтгаанаар хэтэрсэн байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын сан 12.9 тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцох тухай хуулийн дагуу тэтгэврийг өөрчлөн тогтоосонтой холбоотой байна. Мөн өмнөх онтой харьцуулахад тэтгэвэр авагчдын тоо 17.3 мянган хүнээр өссөн нь тодорхой хэмжээгээр нөлөөлсөн,
- Тэтгэмжийн даатгалын сангийн зардал 0.7 тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь төрөх насны эмэгтэйчүүдийн тоо өмнөх оноос 1.2 мянган хүнээр өссөнөөс тус тус шалтгаалжээ.

5.2.4. Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардалд 20.5 тэрбум төгрөг зарцуулахаас 19.9 тэрбум төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 97.1 хувьтай байна.

5.2.5. 2015 онд НДС-гаас хөрөнгө оруулалтад 13.4 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 12.9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал,

/хүснэгт №27/

/тэрбум төгрөг/

5.2.6. Тайлант онд Нийгмийн даатгалын байгууллагад хийгдэх хөрөнгө оруулалтад төлөвлөснөөс 0.5 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ.

Хөрөнгийн зардал	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Барилга, их засвар	10.2	9.8	-0.4	96.1
Тоног төхөөрөмж	1.7	1.6	-0.1	94.1
Бусад хөрөнгө	1.5	1.5	-	100.0
Нийт хөрөнгө оруулалт	13.4	12.9	-0.5	96.3

5.3 Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл

5.3.1. Нийгмийн даатгалын сангийн нийт тэнцэл өмнөх онд 79.8 тэрбум төгрөгийн ашигтай гарч байсан бол 2015 онд 2.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 61.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарснаар сангийн харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл мөн дүнгээр буурсан байна.

БҮЛЭГ 6. Нэмэлт төсвийн гүйцэтгэл

6.1.1. Тайлант онд нэмэлт төсвөөр 269.5 тэрбум төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн нь өмнөх оныхоос 46.1 тэрбум төгрөгөөр бага байна.

6.1.2. Дээрх төвлөрсөн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д²³ зааснаар ангилан харуулбал:

- Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 68.2 тэрбум төгрөг,
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 13.3 тэрбум төгрөг,
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 118.0 тэрбум төгрөг,
- Засгийн газрын болон Засаг даргын нөөцөөс /давхардсан дүнгээр/ 56.2 тэрбум төгрөг,
- УИХ-аас баталсан Засгийн газар хоорондын гэрээ болон Олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл 6.3 тэрбум төгрөг,
- Төсвийн урамшууллагаас 7.5 тэрбум төгрөг тус тус төвлөрсөн байна.

6.1.3. 2015 онд нэмэлт төсвийн гүйцэтгэлээр 254.1 тэрбум, үүнээс улсын төсөвт 199.4 тэрбум, орон нутгийн төсөвт 54.7 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

6.1.4. Нэмэлт төсвөөс бараа үйлчилгээний бусад зардалд 67.9 тэрбум, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 41.9 тэрбум, урсгал шилжүүлэгт 33.5 тэрбум, томилолт, зочны зардалд 31.8 тэрбум, эд хогшил, урсгал засварт 22.2 тэрбум, бусад зардалд 56.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

6.1.5. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын нэмэлт төсвийн 31.2 хувь буюу 62.1 тэрбумыг БХС, 11.0 хувь буюу 22.0 тэрбумыг ХХААС, 10.2 хувь буюу 20.4 тэрбумыг ЭМСС, үлдэх 47.6 хувь 94.9 тэрбум төгрөгийг бусад 26 ТЕЗ зарцуулсан байна.

6.1.6. Орон нутгийн нэмэлт төсвийн нийт зарцуулалтын 36.0 хувь буюу 19.7 тэрбум төгрөг Улаанбаатар хот, 6.5 хувь буюу 3.6 тэрбум төгрөг Өвөрхангай, 5.6 хувь буюу 3.1 тэрбум төгрөг Төв аймагт, үлдэх 51.9 хувь буюу 28.3 тэрбум төгрөг бусад аймагт ногдож байна.

²³ 47.1. Төсвийн захирагч нь дараах нэмэлт төсвийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Монгол Улсын 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн орлогоос бусад үзүүлэлт УИХ-аас баталсан Төсвийн хүрээний мэдэгдлийн шалгуурт нийцсэн байна.
- Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурч, эдийн засгийн өсөлт төлөвлөснөөс саарсан нь Монгол Улсын 2015 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн гүйцэтгэл төлөвлөгөөнөөс 141.7 тэрбум төгрөгөөр тасрахад нөлөөлсөн байна.
- Монгол Улсын 2015 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл 7,530.3 тэрбум төгрөгөөр батлагдаж 7,137.9 тэрбум төгрөг буюу төлөвлөснөөс 392.4 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй, нэгдсэн төсвийн нийт тэнцэл 1,156.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.
- Төсвийн тогтворжуулалтын санд өмнөх оны зэсийн тэнцвэржүүлсэн болон зах зээлийн үнийн зөрүүгээс бий болсон 2.3 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн бөгөөд тайлант онд тус сангаас хөрөнгө зарцуулаагүй байна.
- Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн нийт хэмжээ тайлант оны эцэст 12,124.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь ДНБ-ий 52.3 хувьтай тэнцэж байна.
- Удирдах болон захиргааны ажилтны тоог хязгаарласан орон тооны жишиг норматив байхгүй, зарим орон нутгийн удирдлага Засгийн газрын холбогдох тогтоолыг зөрчин орон тоог нэмэгдүүлсэн нь орон нутаг дахь төсвийн байгууллагын ажиллагсдын тооны хэтрэлтэд нөлөөлсөн байна.

Монгол Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:

Засгийн газраас ирүүлсэн Монгол Улсын 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан 5,983,397.7 сая төгрөгийн орлого, 7,137,973.9 сая төгрөгийн зарлагыг гүйцэтгэлийн аудитаар баталгаажууллаа.

Хавсралт №1

МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Үзүүлэлт	Нэгдсэн төсөв			Улсын төсөв			Орон нутагын төсөв			Үүнээс:			Хүний хөгжил сэн			Нийгмийн баатаглын сэн		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,125,097.7	5,983,397.7	(141,700.0)	4,032,090.2	3,834,039.9	(198,050.3)	2,073,265.5	2,033,759.0	(39,506.5)	356,932.3	423,036.2	66,103.9	1,544,289.2	1,480,479.2	(63,810.0)			
ТОТТОВОРЖУУЛАЛТЫН САН	2,333.7	2,333.7	-	2,333.7	2,333.7	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
1. УТ-Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	2,333.7	2,333.7	-	2,333.7	2,333.7	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
НИЙТ ТЭНЦЭВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,122,764.0	5,981,064.0	(141,700.0)	4,029,756.5	3,831,706.2	(198,050.3)	2,073,265.5	2,033,759.0	(39,506.5)	356,932.3	423,036.2	66,103.9	1,544,289.2	1,480,479.2	(63,810.0)			
А. Урсгал орлогын дүн	5,975,183.1	5,872,486.6	(102,696.5)	3,743,688.7	3,612,533.4	(131,155.3)	825,592.7	818,764.1	(6,828.6)	356,932.3	423,036.2	66,103.9	1,222,645.4	1,187,878.3	(34,767.1)			
1. Татварын орлого	5,110,630.9	5,118,979.5	8,348.6	3,041,421.6	2,943,409.5	(98,012.1)	733,307.6	734,387.3	1,079.7	286,932.3	423,029.8	136,097.5	1,222,645.4	1,187,878.3	(34,767.1)			
1.1 Орлогын албан татвар	998,742.7	1,170,831.3	171,088.6	518,770.3	688,496.8	169,726.5	480,972.4	482,334.5	1,362.1	-	-	-	-	-	-			
1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	480,972.4	482,334.5	1,362.1	-	-	-	480,972.4	482,334.5	1,362.1	-	-	-	-	-	-			
1.1.2 Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	518,770.3	688,496.8	169,726.5	518,770.3	688,496.8	169,726.5	-	-	-	-	-	-	-	-	-			
1.2 Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1,048,979.4	1,018,152.9	(30,826.5)	-	-	-	-	-	-	-	-	-	1,222,645.4	1,187,878.3	(34,767.1)			
1.3 Хөрөнгийн албан татвар	88,529.4	86,610.1	(1,919.3)	-	-	-	88,539.4	86,610.1	(1,929.3)	-	-	-	-	-	-			
1.4 Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,198,628.6	1,049,588.7	(149,039.9)	1,198,628.6	1,049,588.7	(149,039.9)	-	-	-	-	-	-	-	-	-			
1.5 Онцгой албан татвар	644,343.8	592,323.6	(52,020.2)	644,343.8	592,323.6	(52,020.2)	-	-	-	-	-	-	-	-	-			
1.6 Тусгай зориулалтын орлого	11,028.9	11,791.8	762.9	11,028.9	11,791.8	762.9	-	-	-	-	-	-	-	-	-			
1.7 Гадаад үйл ажиллагааны орлого	329,214.8	320,594.9	(8,619.9)	329,214.8	320,594.9	(8,619.9)	-	-	-	-	-	-	-	-	-			
1.8 Бусад татвар (төлбөр, хураамж)	790,163.3	869,086.2	78,922.9	339,435.2	280,613.7	(58,821.5)	163,795.8	165,442.7	1,646.9	286,932.3	423,029.8	136,097.5	-	-	-			
2. Татварын бус орлого	864,552.2	753,507.1	(111,045.1)	702,267.1	669,123.9	(33,143.2)	92,285.1	84,376.8	(7,908.3)	70,000.0	6.4	(69,993.6)	-	-	-			
Б. Хөрөнгийн орлого	84,333.2	55,137.9	(29,195.3)	58,600.0	15,769.6	(42,830.4)	25,733.2	39,368.3	13,635.1	-	-	-	-	-	-			
В. Тусламжийн орлого	63,247.6	53,439.6	(9,808.0)	227,467.8	203,403.2	(24,064.6)	1,221,949.6	1,175,626.6	(46,323.0)	-	-	-	321,643.8	292,600.9	(29,042.9)			

Сая төгрөгөөр/

Хавсралт №2

МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

	ҮЗҮҮЛЭЛТ	Нэгдсэн төсөв			Үүнээс:												Нийгмийн даатгалын сан
		Улсын төсөв			Орон нутагийн төсөв						Хүний хөгжил сан			Нийгмийн даатгалын сан			
		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		7,530,322.6	7,137,973.9	(392,348.7)	5,218,529.6	4,996,886.5	(221,643.1)	2,317,842.9	2,079,164.8	(238,678.1)	328,792.8	308,374.8	(20,418.0)	1,546,636.8	1,541,464.4	(5,172.4)	
А. УРСГАЛ ЗАРДАЛ		5,959,239.4	5,718,373.8	(240,865.6)	4,240,094.2	4,025,377.1	(214,717.1)	1,741,961.6	1,647,262.1	(94,699.5)	325,455.6	305,040.1	(20,415.5)	1,533,207.5	1,528,611.1	(4,596.4)	
1. Баяраа, үйлчилгээний зардал		2,953,754.6	2,801,612.3	(152,142.3)	1,732,647.3	1,639,580.1	(93,067.2)	1,362,559.5	1,300,153.9	(62,405.6)	0.00	0.2	0.2	20,172.9	19,563.4	(609.5)	
1.1. Цөлийн хөлс		1,726,307.5	1,709,772.9	(16,534.6)	957,491.0	948,067.1	(9,423.9)	754,232.2	747,266.3	(6,965.9)	0.0	0.0	-	14,584.4	14,439.5	(144.9)	
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж		161,625.1	157,685.3	(3,939.8)	76,757.1	74,660.3	(2,096.8)	86,264.6	81,463.2	(4,801.4)	0.0	0.0	-	1,603.4	1,561.7	(41.7)	
1.3. Баяраа, үйлчилгээний бусад зардал		1,227,447.1	1,091,839.4	(135,607.7)	698,399.2	616,852.7	(81,546.5)	525,062.7	471,424.4	(53,638.3)	0.0	0.0	-	3,958.1	3,562.1	(396.0)	
2. Хүү		731,251.9	731,055.1	(196.8)	663,792.5	663,721.1	(71.4)	44.0	44.0	-	67,415.4	67,290.0	(125.4)	0.0	0.0	-	
3. Татаас ба урсгал шилжүүлэг		2,274,232.9	2,185,706.3	(88,526.6)	1,843,654.4	1,722,076.0	(121,578.4)	379,358.1	347,064.2	(32,293.9)	258,040.2	237,749.8	(20,290.4)	1,513,034.6	1,509,047.7	(3,986.9)	
3.1. Татаас		104,893.8	110,426.7	5,542.9	76,186.8	47,256.7	(28,930.1)	9,793.7	8,778.5	(1,005.2)	0.00	0.00	-	18,913.3	54,391.5	35,478.2	
3.2. Урсгал шилжүүлэг		2,169,349.1	2,075,279.6	(94,069.5)	1,767,467.6	1,674,819.3	(92,648.3)	369,574.4	338,285.7	(31,288.7)	258,040.2	237,749.8	(20,290.4)	1,494,121.3	1,454,656.2	(39,465.1)	
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,621,369.8	1,396,704.6	(224,665.2)	1,039,697.3	950,712.3	(88,985.0)	564,906.1	429,804.2	(135,101.9)	3,337.2	3,334.7	(2.5)	13,429.3	12,853.3	(576.0)	
1. Дотоод эх үүсвэрээр		1,441,354.2	1,150,579.8	(290,774.4)	859,681.6	704,587.6	(155,094.0)	564,906.1	429,804.2	(135,101.9)	3,337.2	3,334.7	(2.5)	13,429.3	12,853.3	(576.0)	
1. Барилга байгууламж		614,609.2	442,261.0	(172,348.2)	302,976.6	214,934.4	(88,042.2)	294,866.2	211,138.5	(83,727.7)	3,337.2	3,334.7	(2.5)	13,429.3	12,853.3	(576.0)	
2. Иж засвар		148,944.2	110,773.2	(38,171.0)	27,338.3	19,746.2	(7,592.1)	121,606.1	91,026.9	(30,579.2)	0.0	0.0	-	0.0	0.0	-	
3. Хөрөнгийн бусад зардал		225,449.5	163,895.0	(61,554.5)	77,015.7	36,256.3	(40,759.4)	148,433.8	127,638.7	(20,795.1)	0.0	0.0	-	0.0	0.0	-	
4. Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгөө оруулалт		452,351.0	433,650.6	(18,700.4)	452,351.0	433,650.6	(18,700.4)	0.0	0.0	-	0.0	0.0	-	0.0	0.0	-	
2. Гадаад эх үүсвэрээр		180,015.7	246,124.8	66,109.1	180,015.7	246,124.8	66,109.1	0.0	0.0	-	0.0	0.0	-	0.0	0.0	-	
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ		(50,286.6)	22,895.4	73,182.0	(61,261.8)	20,797.0	82,058.8	10,975.2	2,098.4	(8,766.8)	0.0	0.0	-	0.0	0.0	-	
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл		(97,628.4)	(17,588.9)	80,039.5	(97,628.4)	(17,588.9)	80,039.5	0.0	0.0	-	0.0	0.0	-	0.0	0.0	-	
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл		47,341.8	40,484.3	(6,857.5)	38,385.8	(45,243.3)	(83,629.1)	2,098.4	(85,727.5)	(87,825.9)	0.0	0.0	-	0.0	0.0	-	

/сая төгрөгөөр/

Хаясралт №3

МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

ҮЗҮҮЛЭЛТ	Нэгдсэн төсвө			Улсын төсвө			Орон нутагийн төсвө			Хүний хөгжил сан			Нийгмийн даатгалын сан		
	төлөвлөсөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөсөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөсөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөсөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөсөө	гүйцэтгэл	зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,125,097.7	5,983,397.7	(141,700.0)	4,032,090.2	3,834,039.9	(198,050.3)	2,073,265.5	2,033,759.0	(39,506.5)	356,832.3	423,036.2	66,103.9	1,544,289.2	1,480,479.2	(63,810.0)
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	2,333.7	2,333.7	-	2,333.7	2,333.7	-	0.0	0.0	0.0	0.0	0.0	-	0.0	0.0	-
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,122,764.0	5,981,064.0	(141,700.0)	4,029,756.5	3,831,706.2	(198,050.3)	2,073,265.5	2,033,759.0	(39,506.5)	356,832.3	423,036.2	66,103.9	1,544,289.2	1,480,479.2	(63,810.0)
Урсгал орлогын дүн	6,122,764.0	5,981,064.0	(141,700.0)	4,029,756.5	3,831,706.2	(198,050.3)	2,073,265.5	2,033,759.0	(39,506.5)	356,832.3	423,036.2	66,103.9	1,544,289.2	1,480,479.2	(63,810.0)
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,530,322.6	7,137,973.9	(392,348.7)	5,218,529.6	4,996,886.5	(221,643.1)	2,317,842.9	2,079,164.8	(238,678.1)	328,792.8	308,374.8	(20,418.0)	1,546,636.8	1,541,464.4	(5,172.4)
Урсгал зарлагын дүн	5,959,239.4	5,718,373.8	(240,865.6)	4,240,094.2	4,025,377.1	(214,717.1)	1,741,961.6	1,647,262.1	(94,699.5)	325,455.6	305,040.1	(20,415.5)	1,533,207.5	1,528,611.1	(4,596.4)
ТӨСВИЙН НИЙТ ТЭНЦЭЛ	(1,407,588.6)	(1,156,909.8)	250,678.8	(1,188,773.1)	(1,165,180.3)	23,592.8	(244,577.4)	(45,405.7)	199,171.7	28,139.5	114,661.4	86,521.9	(2,347.6)	(60,985.2)	(58,637.6)
АЛДАГ ДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,407,588.6	1,156,909.8	(250,678.8)	1,188,773.1	1,165,180.3	(23,592.8)	244,577.4	45,405.7	(199,171.7)	(28,139.5)	(114,661.4)	(86,521.9)	2,347.6	60,985.2	58,637.6
1. Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(226,319.6)	(43,861.0)	182,458.6	(474,478.6)	(94,434.6)	380,044.0	228,388.0	41,017.1	(187,370.9)	17,423.4	(51,428.7)	(68,552.1)	2,347.6	60,985.2	58,637.6
2. 3Г-ын фонд	1,068,485.0	681,425.7	(387,059.3)	1,072,451.2	691,762.7	(380,688.5)	0.0	0.0	0.0	(3,966.2)	(10,337.0)	(6,370.8)	0.0	0.0	-
2.1. Урт хугацаат	1,068,485.0	681,425.7	(387,059.3)	1,072,451.2	691,762.7	(380,688.5)	0.0	0.0	0.0	(3,966.2)	(10,337.0)	(6,370.8)	0.0	0.0	-
2.1.1. Дотоод	753,485.0	366,870.5	(386,614.5)	757,451.2	377,207.5	(380,243.7)	0.0	0.0	0.0	(3,966.2)	(10,337.0)	(6,370.8)	0.0	0.0	-
2.1.1.1. Шинээр гаргах	2,795,183.8	1,359,201.8	(1,435,982.0)	2,485,000.0	1,179,369.0	(1,305,631.0)	0.0	0.0	0.0	310,183.8	179,832.8	(130,351.0)	0.0	0.0	-
2.1.1.2. Үндсэн төлбөр	(2,041,698.8)	(992,331.3)	1,049,367.5	(1,727,548.8)	(802,161.5)	925,387.3	0.0	0.0	0.0	(314,150.0)	(190,169.8)	123,980.2	0.0	0.0	-
2.1.2. Гадаад	315,000.0	314,929.1	(70.9)	315,000.0	314,929.1	(70.9)	0.0	0.0	0.0	0.0	0.0	-	0.0	0.0	-
2.1.2.1. Шинээр гаргах	315,000.0	314,929.1	(70.9)	315,000.0	314,929.1	(70.9)	0.0	0.0	0.0	0.0	0.0	-	0.0	0.0	-
2.2. Богино хугацаат	0.0	(373.9)	(373.9)	0.0	(373.9)	(373.9)	0.0	0.0	0.0	0.0	0.0	-	0.0	0.0	-
2.2.1. Дотоод	1.00	(372.9)	(373.9)	1.00	(372.9)	(373.9)	0.0	0.0	0.0	0.0	0.0	-	0.0	0.0	-
2.2.1.1. Шинээр гаргах	1,119,819.2	1,077,570.7	(42,248.5)	1,119,819.2	1,077,570.7	(42,248.5)	0.0	0.0	0.0	0.0	0.0	-	0.0	0.0	-
2.2.1.2. Үндсэн төлбөр	(1,119,819.2)	(1,077,570.7)	42,248.5	(1,119,819.2)	(1,077,570.7)	42,248.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	-	0.0	0.0	-
3. 3Г-ын зээл	606,989.9	572,240.8	(34,749.1)	590,800.5	567,852.2	(22,948.3)	16,189.4	4,388.6	(11,800.8)	0.0	0.0	-	0.0	0.0	-
3.1. Дотоод	307,124.1	188,261.5	(118,862.6)	307,124.1	188,261.5	(118,862.6)	0.0	0.0	0.0	0.0	0.0	-	0.0	0.0	-
3.1.1. Монгол банк (ОУБС)	(5,323.3)	(5,254.7)	68.6	(5,323.3)	(5,254.7)	68.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	-	0.0	0.0	-
3.1.1.1. Үндсэн төлбөр	(5,323.3)	(5,254.7)	68.6	(5,323.3)	(5,254.7)	68.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	-	0.0	0.0	-
3.1.2. Авлага	(139,903.6)	(240,134.4)	(100,230.8)	(139,903.6)	(240,134.4)	(100,230.8)	0.0	0.0	0.0	0.0	0.0	-	0.0	0.0	-
3.1.2.1. Үндсэн төлбөр	(139,903.6)	(240,134.4)	(100,230.8)	(139,903.6)	(240,134.4)	(100,230.8)	0.0	0.0	0.0	0.0	0.0	-	0.0	0.0	-
3.1.3. Төсвөөс эргэн төлөгдөх	452,351.0	433,650.6	(18,700.4)	452,351.0	433,650.6	(18,700.4)	0.0	0.0	0.0	0.0	0.0	-	0.0	0.0	-
3.1.3.1. Авх	452,351.0	433,650.6	(18,700.4)	452,351.0	433,650.6	(18,700.4)	0.0	0.0	0.0	0.0	0.0	-	0.0	0.0	-
3.2. Гадаад	299,865.8	383,979.2	84,113.4	283,676.4	379,590.6	95,914.2	16,189.4	4,388.6	(11,800.8)	0.0	0.0	-	0.0	0.0	-
3.2.1. Төслийн зээл	97,365.8	184,753.2	87,387.4	81,176.4	180,364.6	99,188.2	16,189.4	4,388.6	(11,800.8)	0.0	0.0	-	0.0	0.0	-
3.2.1.1. Шинээр авах	238,766.4	305,867.9	67,101.5	222,577.0	301,479.3	78,902.3	16,189.4	4,388.6	(11,800.8)	0.0	0.0	-	0.0	0.0	-
3.2.1.2. Үндсэн төлбөр	(141,400.6)	(121,114.6)	20,286.0	(141,400.6)	(121,114.6)	20,286.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-	0.0	0.0	-
3.2.2. Хөтөлбөрийн болон төслийн бус зээл	202,500.0	199,226.0	(3,274.0)	202,500.0	199,226.0	(3,274.0)	0.0	0.0	0.0	0.0	0.0	-	0.0	0.0	-
3.2.2.1. Шинээр	202,500.0	199,226.0	(3,274.0)	202,500.0	199,226.0	(3,274.0)	0.0	0.0	0.0	0.0	0.0	-	0.0	0.0	-
4. Урьдчилгаа орлого	139,903.6	240,134.4	100,230.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	139,903.6	240,134.4	100,230.8	0.0	0.0	-
5. Урьдчилгаа орлогоос орлогод тооцсон	(181,500.3)	(293,030.0)	(111,529.7)	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	(181,500.3)	(293,030.0)	(111,529.7)	0.0	0.0	-



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2016 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23 дугаар зүйлийн 2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд хүргүүлсүгэй.
3. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилгах арга хэмжээ авч, түүний үр дүнг 2017 оны 5 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд нарт зөвлөсүгэй.
4. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилгах арга хэмжээнд хяналт тавьж, үр дүнг Удирдлагын зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэлийн аудитын газрын дарга М.Наранжаргалд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД